

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО: УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

А.АЛТАНЗУЛ

ХУЧУЛЬ ЗҮЙН ДОКТОР
УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН БАГШ, ДЭД ПРОФЕССОР

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛ
2021 ОН

© Энэхүү бүтээлийг америкийн ард түмний дэмжлэгээс бүрдсэн АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтай, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд бүтээв.

Бүтээлд илэрхийлэгдсэн үзэл санаанууд нь уг бүтээлийн зохиогчдын үзэл санаа бөгөөд АНУ-ын Засгийн газар, эсхүл дээрх агентлаг, хүрээлэн, сангийн албан ёсны байр суурь биш болно.



АГУУЛГЫН ТОВЬЁГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ	5
1.1 Товч үндэслэл	5
1.2. Судалгааны зорилго	6
ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГАДСАН БАЙДЛЫН ТОЙМ	7
2.1. Хөгжлийн тухай товч ойлголт.....	7
2.2. Сэдвийн хүрээнд гарсан бүтээл	8
2.3. Судалгааны парадигм, үзэл баримтлал	9
2.4. Судалгааны асуулт	10
2.5. Судалгааны таамаглал:	11
ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	12
3.1. Судалгааны төрөл, түүний зорилго	12
3.2. Судалгааны эх олонлог, түүвэр.....	12
3.3. Судалгааны хэмжүүр.....	12
3.4. Өгөгдөл цуглуулах	12
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ӨГӨГДЛИЙН БОЛОВСРУУЛАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН	14
4.1. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг тодорхойлсон Монгол Улсын бодлогын баримт бичиг гарсан, эсэх	16
4.2. Улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрт Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал тусгагдсан байдал	24
4.3. Сонгуулийн дараа төр, засгийн шийдвэрт Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал тусгагдсан, эсэх.....	33
4.4 Сонгогч Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, бодлогыг ухамсарлан саналаа өгдөг, эсэх.....	43
ТАВДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ	55
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	2

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АИХ	Ардын Их Хурал
АН	Ардчилсан Нам
ИЗН	Иргэний Зориг Нам
ИЗНН	Иргэний Зориг Ногоон нам
МАН	Монгол Ардын Нам
МАХН	Монгол Ардын Хувьсгалт Нам
МоАН	Монголын Ардчилсан Нам
МоАХ	Монголын Ардчилсан Холбоо
МСДН	Монголын Социал Демократ нам

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Тогтвортой хөгжлийн тулгуур ойлголтуудын харьцаа.....	9
Зураг 2. Асуулт 1: Та намуудын сонгуулийн хөтөлбөрийг судалж саналаа өгсөн үү?....	43
Зураг 3. Асуулт 2: Тухайн үеийн БНМАУ-ын хөгжлийн үзэл баримтлалыг санаж байна уу гэсэн асуултыг авсан.....	43
Зураг 4. Асуулт 3: Таны санал өгсөн намын мөрийн хөтөлбөрт заасан зорилт өнөө цаг үе хүртэл бодитой хэрэгжиж чадсан уу?	44
Зураг 5. Асуулт 1: Та намуудын сонгуулийн хөтөлбөрийг судалж саналаа өгсөн үү?....	45
Зураг 6. Асуулт 2: Тухайн үеийн Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг санаж байна уу гэсэн асуултыг авсан.....	45
Зураг 7. Асуулт 3: Таны санал өгсөн намын мөрийн хөтөлбөрт заасан зорилт өнөө цаг үе хүртэл бодитой хэрэгжиж чадсан уу?	46
Зураг 8. Асуулт 1: Та намуудын сонгуулийн хөтөлбөрийг судалж саналаа өгсөн үү?...	47
Зураг 9. Асуулт 2: Тухайн үеийн Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын бодлогын баримт бичгийг санаж байна уу?	47
Зураг 10. Асуулт 3: Таны санал өгсөн намын мөрийн хөтөлбөрт заасан зорилт өнөө цаг үе хүртэл бодитой хэрэгжиж чадсан уу?	48
Зураг 11. Асуулт 1: Та намуудын сонгуулийн хөтөлбөрийг судалж саналаа өгсөн үү?...	48
Зураг 12. Асуулт 2: Тухайн үеийн Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг санаж байна уу гэсэн асуултыг авсан.....	49
Зураг 13. Асуулт 3: Таны санал өгсөн намын мөрийн хөтөлбөрт заасан зорилт өнөө цаг үе хүртэл бодитой хэрэгжиж чадсан уу?	49
Зураг 14. Асуулт 1: Та намуудын сонгуулийн хөтөлбөрийг судалж саналаа өгсөн үү?...	50
Зураг 15. Асуулт 2: Тухайн үеийн Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг санаж байна уу гэсэн асуултыг авсан.....	50
Зураг 16. Асуулт 3: Таны санал өгсөн намын мөрийн хөтөлбөрт заасан зорилт өнөө цаг үе хүртэл бодитой хэрэгжиж чадсан уу?	51
Зураг 17. Асуулт 1: Та намуудын сонгуулийн хөтөлбөрийг судалж саналаа өгсөн үү?...	51
Зураг 18. Асуулт 2: Тухайн үеийн Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг санаж байна уу гэсэн асуултыг авсан.....	52
Зураг 19. Асуулт 3: Таны санал өгсөн намын мөрийн хөтөлбөрт заасан зорилт өнөө цаг үе хүртэл бодитой хэрэгжиж чадсан уу?	52
Зураг 20. Асуулт 1: Та намуудын сонгуулийн хөтөлбөрийг судалж саналаа өгсөн үү?...	53
Зураг 21. Асуулт 2: Тухайн үеийн Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг санаж байна уу гэсэн асуултыг авсан.....	53
Зураг 22. Асуулт 1: Та намуудын сонгуулийн хөтөлбөрийг судалж саналаа өгсөн үү?...	54
Зураг 23. Асуулт 2: Тухайн үеийн Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг санаж байна уу гэсэн асуултыг авсан.....	54

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Судалгааны асуулт 1	10
Хүснэгт 2. Судалгааны асуулт 2	10
Хүснэгт 3. Судалгааны асуулт 3	11
Хүснэгт 4. Судалгааны асуултыг шалгах шалгуур үзүүлэлт	12
Хүснэгт 5. Иргэдээс авах түүврийн мэдээлэл	13
Хүснэгт 6. Тогтвортой хөгжлийн үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан байдал	19
Хүснэгт 7. Тогтвортой хөгжлийн үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан байдал	20
Хүснэгт 8. Тогтвортой хөгжлийн үндсэн шалгуур үзүүлэлтийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал хангасан байдал	21
Хүснэгт 9. Тогтвортой хөгжлийн үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан байдал	21
Хүснэгт 10. Намуудын мөрийн хөтөлбөр-1990 ба Хөгжлийн үзэл баримтлал.....	24
Хүснэгт 11. Намуудын мөрийн хөтөлбөр-1992 ба Хөгжлийн үзэл баримтлал.....	26
Хүснэгт 12. Намуудын мөрийн хөтөлбөр-1996 ба Хөгжлийн үзэл баримтлал.....	27
Хүснэгт 13. Намуудын мөрийн хөтөлбөр-2000 ба Хөгжлийн үзэл баримтлал.....	28
Хүснэгт 14. Намуудын мөрийн хөтөлбөр-2004 ба Хөгжлийн үзэл баримтлал.....	30
Хүснэгт 15. Намуудын мөрийн хөтөлбөр-2008 ба Хөгжлийн үзэл баримтлал.....	31
Хүснэгт 16. Намуудын мөрийн хөтөлбөр-2012 ба Хөгжлийн үзэл баримтлал.....	32
Хүснэгт 17. Намуудын мөрийн хөтөлбөр-2016 ба Хөгжлийн үзэл баримтлал.....	33

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ

1.1 Товч үндэслэл

БНМАУ-ын АИХ-ын анхны ардчилсан сонгууль, шинэ Үндсэн хуулиа баталснаас хойш УИХ-ын сонгуулийг найман удаа буюу нийт төлөөллийн байгууллагын есөн удаагийн сонгууль зохион байгуулжээ. 1992 оноос хойших сонгуулиудад нэг удаа буюу 2012 онд пропорциональ, мажоритарыг хослуулсан холимог тогтолцоог хэрэглэсэн. Бусад долоон тохиолдолд мажоритарыг сонгосон бөгөөд үүний дөрөв нь жижигсгэсэн мажоритар буюу нэг мандаттай 76 тойргоор явуулжээ. Харин хоёрт нь буюу 1992, 2008, 2020 онд томсгосон мажоритараар сонгууль явуулсан.

Сонгуулийн тогтолцоог тойрог ямар байх, сонгогч саналаа яаж өгөх, намуудын кампанит ажлын стратеги, нэр дэвшигч хэн байх, намын бодлого ямар байх, сонгогчдын саналыг хэрхэн татах, авсан саналыг яаж парламентад шилжүүлэх зэрэг олон асуудлыг багтаадаг өргөн хүрээтэй ойлголт гэж үздэг (Э.Гэрэлд-Од).

Гэхдээ УИХ-ын найман удаагийн сонгууль болсны дараах нөхцөл байдлаас дүгнэхэд сонгуулийн тогтолцооны сайн муу хувилбарын тухай асуудал сонгуулийн зардал, сурталчилгаа, санал хураалтын явцад тавих хяналт ил тод байх, сонгуулийг хууль ёсны явуулахад нөлөөлөхөөс биш, аль нэг тогтолцоог сонгосноор л бүх зүйл сайхан болчихдог гэвэл өрөөсгөл юм.

Угтаа бол сонгууль нь сонгогч иргэний Үндсэн хуульд заасан “Засгийн бүх эрх мэдэл ард түмний гарт байх” эрхээ иж бүрнээр эдлэх (нэг удаагийн биш) хамгийн чухал боломж боловч саналаа өгсөн хүн бүр үүнийг гүн гүнзгий ойлгон сонголт хийх нь харилцан адилгүй байдаг.

Өнөөдөр сонгогч урт хугацаанд үйлчлэх үнэт зүйлсэд ач холбогдол өгөх нь буурч сонгууль болох жилийн нэгдүгээр сараас эхлэн санал өгөх өдрийн өмнөх буюу сурталчилгаа дууссан өдөр хүртэлх хугацаанд болсон нийгэм, эдийн засаг, улс төр, соёл, түүнчлэн давагдашгүй нөхцөл байдлаас урган гарсан богино хугацааны хүчин зүйлсэд автаж саналаа өгч байгааг судлаачид тэмдэглэсэн байна¹. Энэ нь зөвхөн манай улсынх бус, бусад улс оронд ч мөн адил илэрдэг. Үүний шалтгааны талаар олон тайлбар гаргах боловч өнөөдөр дэлхийн улс орнуудад террорист халдлага, цагаач, дүрвэгсдийн асуудал, ажилгүйдэл, ядуурал зэргийг “түлхүүр үгс” болгон сонгогчдын сэтгэл зүйд нөлөөлөх байдал АНУ, Их Британи, Германы жишээн дээр ч ажиглагдаж байна. Хэдийгээр эдгээр асуудлыг тулгамдсан гэж үзэх нь үндэслэлтэй ч урт хугацаандаа хүний эрх, энх тайвнаар хамтран оршин тогтнох, тогтвортой хөгжил зэрэгт сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай гэж таамаглаж байна. Нөгөө талаас дээрх *түлхүүр үгсийг* ашиглан хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тэр дундаа технологийн хөгжлийн үр дүн болох социал хэрэгслийн тусламжтайгаар улстөрч, намууд “хялбар” ялах боломжтой болжээ. Сонгогчид судалгаа шинжилгээнд суурилсан урт, үргэлжилсэн мэдээ, мэдээллийг уншихаас илүүтэйгээр тухайн улс төр, намуудын олон

¹ Ц.Мөнхцэцэг. Сонгуулийн кампанийн коммуникаци. 2018.

нийтэд хандсан “*тулхуур үг*” –энд ач холбогдол өгдөг болсныг сүүлийн үеийн сонгуулийн үр дүнгүүд илтгэж байна.

Энэ судалгааны хувьд сонгуулийн тогтолцооны хувилбарыг дэвшүүлэхийг урьтал болгосонгүй, харин сонгуулийн үр дүнд бий болсон төр, засгийн бодлого тогтворгүй, залгамж халаа байхгүй, хэт ойрын зайн улс төрийн бодлого нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн философид хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох, энэ талаар сонгогчийн ойлголт, мэдээлэл ямар түвшинд байгааг судлах зорилготой болно.

1990-ээд онд манай оронд өөрчлөлт шинэчлэлт эхэлснээс хойш даруй 20 гаруй жил улиран өнгөрсөн ч олон намууд, төр засгаас дэвшүүлсэн хөтөлбөрт хөгжлийн философи үгүйлэгдээд удаж байна гэж профессор Б.Даш-Ёндон² дүгнэн бичсэнтэй санал нийлж байна. Мөн хөгжлийн үзэл баримтлалыг зөвхөн эдийн засгийн хэрэглээний онол арга зүйд голлон авч үзэх нь учир дутагдалтай бөгөөд байгаль, нийгэм, эдийн засгийн харилцан тэнцвэрийг хангах тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг улс төрийн нам, сонгогч ухамсарлах аваас сонгуулийн үр дүн бодитой болж, төрийн залгамж чанар хадгалагдах болно гэж судлаач үзэж байна.

1.2. Судалгааны зорилго

“Урт хугацааны, тодруулбал, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрт хэрхэн тусгагдаж байсан, эсэх, хэрэв тусгагдсан бол хэрэгжилт ямар байсныг тодорхой үзүүлэлтүүдийг түүвэрлэн авч үзэх замаар сонгогчийн итгэл үнэмшилтэй хэрхэн харилцан хамааралтай байгааг тодорхойлохыг зорилоо.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

² Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус). 2017. х.70-71

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

2.1. Хөгжлийн тухай товч ойлголт

Хүн төрөлхтөн оюун ухааны шилдэг өөрчлөлт, дэвшлийн ерөнхий зүй тогтлыг олон зууны турш эрэн сурвалжилж, хөгжлийн тухай онол, үзэл баримтлал олныг боловсруулж иржээ³. XIX зууны сүүлээр Грек-Ромын соёл иргэншлээс үүдэлтэй барууны нийгэмд нийгмийн сайн сайхан байдалд хүрэх тухай үзэл баримтлалууд хүчтэй яригдах болсон.

Хөгжлийн үйл явц нь хүмүүсийн сонголтыг сайжруулахад чиглэгдсэн байдаг. Хүн аливаа сонголтыг хийхийн тулд боловсрол, мэдлэгтэй, эрүүл чийрэг байхаас гадна өөрийн гэсэн үнэт зүйл бүхий амьдралыг цогцлоох чадвартай байх ёстой. Ингэснээр хүн амьдралын тодорхой зорилготой болж, илүү олон боломж бүрдэж, мөн орлогоо нэмэгдүүлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх нөхцөл бүрдэнэ.

Улс орнуудад хэрэгжүүлж буй хөгжлийн талаарх үзэл баримтлал, онолуудыг судлаачид ерөнхийд нь глобал ба эндогени үзэл баримтлал гэж хоёр ангилан шинжилсэн байх аж⁴. Глобал шинжтэй үзэл баримтлал НҮБ-ын бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан байдаг.

1960-аад оноос НҮБ болон түүний харьяа байгууллагууд нь хөгжлийг эдийн засгийн өсөлттэй адилтгадаг үзэл баримтлал, түүнтэй төсөөтэй онолуудыг баримталж байв⁵. Харин техникийн дэвшил, эдийн засгийн засгийн өсөлт зэрэг нь тухайн цаг үетэйгээ л холбогддог, гарах үр дагавар хэтдээ сайнаар бас сөргөөр ч нөлөөлдөг.

Түүх сөхөхөд манай улс 1940 онд малын тоо толгойг 10-13 жилд 23 саяас 200 сая хүргэх зорилтыг⁶ тухайн үеийн нам засгийн хөтөлбөрт тусгаж байлаа. Гэтэл бэлчээрийн мал аж ахуйтай улсын хувьд малын тоо толгойг ийнхүү өсгөх нь алсдаа эргээд мал бэлчээрлэх газаргүй болох, энэ нь байгалийн унаган төрх алдагдах, мөн малаас гарах ашиг шим муудах зэрэг сөрөг үр дагавартай байх билээ.

XXI зуунд хөгжлийн зорилт нь тогтвортой хөгжлийг хангахад чиглэж байна. Энэ нь өнөөгийн хэрэгцээгээ хангахдаа хойч үеийнхээ хэрэгцээг хангах боломжийг хязгаарлахгүй хөгжих явдал юм⁷.

Иймд хүн төрөлхтөн хөгжлийн зөвхөн эдийн засгийн хэрэглээний онолд тулгуурлан цаашид явах аваас манай дэлхийд байгаль орчны сүйрэл, эдийн засгийн хямрал, нийгмийн шударга бус байдал улам нэмэгдэнэ гэдгийг танин мэдсэний үр дүнд, ирээдүйд чиглэсэн, хувьсал өөрчлөлтөд нээлттэй тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын загвар боловсруулсан.

³ Ч.Ган-Өлзий. Тогтвортой хөгжил: оюуны ертөнцийн философи. 2018. х.5

⁴ Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх субъектив хүчин зүйлсийн шинжилгээ. ШУА, Философийн хүрээлэн. 2019. х. 12

⁵ Мөн тэнд

⁶ Д.Эрдэнэбат. Дэлхий Хоёрдугаар дайны Монгол улсын эдийн засаг. 2017.

⁷ 'Хүний хөгжлийн гарын авлага: Ойлголт, хэмжүүр ба бодлого', Сакико Фукуда Парранд, А.К.Шива, Оксфордын Их сургууль, Нью-Йорк, 1995. See for definitions, Handbook of Human Development: Concepts, Measures, and Policies, Sakiko Fukuda-Parr and A.K. Shiva Kumar (Eds.), Oxford University Press, New York. 1995. Төлөвлөлт-хяналт шинжилгээ, үнэлгээний гарын авлага. 2015.

НҮБ-ын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг Брундтландын комисс “Манай ирээдүй” (1978 он) тайландаа энэхүү үзэл баримтлал нь “хүмүүний нийгэмлэгийн тогтвортой хөгжил” хэмээх нэр томъёог өргөн ашигласны үр дүнд НҮБ-ын хүрээнд цаашдын хөгжлөө олсон байна. Үүнээс хойш 1992 онд Рио де Жанейро хотод зохион байгуулагдсан НҮБ-ын Рио-гийн “Байгаль орчин ба Хөгжил” даян дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалтаар тогтвортой хөгжлийн тунхаглалын 27 зарчмыг баталж, НҮБ-ын гишүүн орон бүр өөрсдийн ХХI зууны Тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрөө боловсруулах үүрэг амлалт авсан.

Тогтвортой хөгжлийн хүчин зүйл нь хүний амьдралын чанарыг сайжруулж, биологи, нийгэм, эдийн засаг, соёл, улс төр, эд материал болон экологийн зэрэг нөхцөл байдлыг тооцоолон хүний нөөцийн хөгжлийг өөртөө агуулдаг учраас энэ үзэл хандлага богино хугацаанд нийтэд хүлээн зөвшөөрөгджээ. Өөрөөр хэлбэл, зөвхөн эдийн засгийг хөгжүүлэхээс гадна байгаль орчныг хамгаалах, нийгмийн амар тайван байдал, уламжлалт соёл, зан заншилд зохицсон энгийн хэрэглээг дэмжсэн нийгэм, эдийн засгийн тэнцвэрт хөгжлийг хангахыг хэлнэ.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал бол монгол хүний хувьд цоо шинэ зүйл биш. Угаасаа нүүдлийн соёл иргэншлээс улбаатайгаар байгаль дэлхийтэйгээ зохицох, энгийн минимал эдийн засгийн амьдралтай байсан ард түмэн билээ.

Монголчуудын хувьд төрт ёсны түүхэн уламжлал арвин бөгөөд энэ талаар өөрийн гэсэн онцлог үндэсний бодлогоо үе дамжуулан уламжлуулж ирсэн. Гэхдээ энэ судалгааны үндсэн шинжилгээ нь сонгуулийн үйл явц, тогтолцоотой холбогдож байгаа учраас анхны ардчилсан сонгуулиас эхлэн түүхийн цаг хугацааг эхлүүлсэн болно.

2.2. Сэдвийн хүрээнд гарсан бүтээл

Сонгуулийн тогтолцоо, сонгуулийн кампани, коммуникаци, сонгогчийн боловсрол, зан байдал зэргээр маш олон тооны судалгаа, гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл хэвлэгдэн гарсан. Сонгуулийн харилцааг улс төр, эрх зүй, эдийн засаг, социологийн салбарын эрдэмтэн судлаачид өөр өөрийн судалгааны арга зүйг баримтлан судалсан билээ. Тухайлбал, судлаач академич Г.Чулуунбаатар, доктор Ц.Уртнасан, Б.Чимид, Д.Баасансүрэн, Д.Болд-Эрдэнэ, Ц.Мөнхцэцэг, С.Мөнхбат, Э.Гэрэлт-Од, О.Машбат, О.Хатанболд, Д.Бумдарь, Төртогтох, О.Мөнхсайхан зэрэг эрдэмтэн судлаачийн бүтээлд дурдагдсан байна. Мөн намуудын мөрийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийсэн судалгаанууд бий. Үүнд судлаач Ч.Баатар 2008 онд сонгуульд оролцсон намуудын мөрийн хөтөлбөрт нийгмийн бодлогын асуудлыг тусгасан гэсэн эрдэм шинжилгээний илтгэлд: намуудын мөрийн хөтөлбөр гэж зөвхөн ялахын тулд хийсэн уриа биш, цаашид гүйцэтгэх ажлаа андгайлсан амлалт, нэг ёсондоо гэрээ юм гээд 2008 онд сонгуульд оролцсон намуудын мөрийн хөтөлбөрт нийгмийн бодлогын асуудлыг тоо баримтад тулгуурлан судалжээ.

Монгол Улсын хөгжлийн философи, зарчимд тулгуурлан сонгуулийн тогтолцооны талаар бичсэн бүтээл ховор байна.

Судлаачийн хувьд судалгаандаа ашигласан судлаачдын бүтээл, гарын авлагыг эшлэл болон эх сурвалж гэсэн бүлэгт багтаасан болно.

2.3. Судалгааны парадигм, үзэл баримтлал


Судлаачийн хувьд судалгааны релятивист буюу интерпретивист чиглэлийг баримтлан судалгааны парадигмыг тодорхойлсон. Энэ нь үзэгдэлд олон талаас нь хандах, олон ургалч үзлийг уулзуулж, олон төрлийн мэдлэгийг шүтэлцүүлэх аргыг чухалчилдаг⁸.

Тогтвортой хөгжлийн талаарх олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн зарчим бол байгаль орчин, нийгэм, эдийн засаг гэсэн гурван үндсэн тулгуур асуудал ижил түвшинд хангагдаж байх явдал юм. Энэхүү гурван асуудал бие биеэсээ хамааралтай, харилцан шүтэлцээтэй бөгөөд тогтвортой хөгжлийн бүрэлдэхүүн хэсгүүд мөн. Тодруулбал, эдгээрийн харилцаа холбоо, хамаарал нь улс төрийн бодлого, эрх зүйн тодорхой зохицуулалтаар дамжин хэрэгждэг байна.

Өнөөгийн байдлаар эдгээр тулгуур ойлголт нь ямар харьцаатай байгааг зургаар үзүүлбэл:

Зураг 1. Тогтвортой хөгжлийн тулгуур ойлголтуудын харьцаа

а. одоогийн байдал



б. хүрэх түвшин (Бадарч Д., 2014, х.71)



Энэхүү холбоо, хамаарлын харьцааг зохистой хэмжээнд уялдуулан зохицуулж зорилгод түвшинд нь хүргэхэд улс төрийн хүчин зүйл буюу улс төрийн тогтолцоо, түүний бүрдэл хэсгүүдийн зөв төлөвшил, хууль тогтоомжийн оновчтой зохицуулалт шийдвэрлэх үүрэгтэй. Тэдгээрийг тогтвортой хөгжлийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг бүрээр тоймлон үзвэл:

1. Байгаль орчны үндсэн тулгуур асуудлууд нь уур амьсгалын зохицуулалт, байгалийн нөөц болон биологийн төрөл зүйлийг хамгаалах, хүнсний үйлдвэрлэл болон байгалийн усны хангамж зэрэг болно.

2. Эдийн засгийн өсөлтийг бий болгохдоо байгаль орчны доройтол, бохирдлоос сэргийлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан, хүн амын амьдралын чанарыг сайжруулж, нийгмийн тэгш байдлыг хангахад оршино. Байгалийн баялгийг амьжиргаагаа дээшлүүлэх, байгаль хамгаалах үндсийг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн зохистой ашиглаж, зах зээлд өрсөлдөх чадвартай, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх шаардлагатай.

3. Бүх нийтийг нийгмийн суурь үйлчилгээгээр хангах нь суурь чадамжуудыг бий болгох асуудал бөгөөд бүх нийтэд хүртээмжтэй, адил тэгш боломж олгох явдал юм. Хүн бүрийг тэгш сайхан амьдралаар амьдруулахын тулд боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, ундны усны хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн болон аюулгүй байдлыг нь хангах зэрэг нийгмийн суурь үйлчилгээг хувь хүний

⁸ Г.Жаргал. Судалгааны арга зүйд өөрөө сурах бичиг. 2018 он. х.26

төлбөрийн чадвараас хамааралгүйгээр эрх тэгш хүртээх учиртай. Цаашилбал, суралцах илүү сайн давуу боломжуудыг нээж өгөх, мэдээллийн хүртээмжийг сайжруулах, хүний эрх, үүргийн талаарх иргэдийн ойлголтыг нэмэгдүүлэх, хүйсийн тэгш эрхт байдлыг хангах, ядуурлыг бууруулах зэрэг хүн төрөлхтний хөгжин цэцэглэхийн төлөөх нийгмийн асуудлууд болно.

Монгол Улсын хувьд 1993 онд УИХ-аас тогтвортой хөгжлийн чиг баримтлалын үзэл санааг Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт тусгаж байх нь зүйтэй гэсэн тогтоол гаргасан. Үүний дагуу УИХ-аас 1996 онд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал: 1996-2015, 1998 онд ХХI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр: 1998-2021, “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт” (2005), Үндэсний хөгжлийн цогц бодлого (2008), 2016 онд Тогтвортой хөгжил- 2030, 2020 онд Алсын хараа-2050 зэргийг тус тус баталсан.

Тогтвортой хөгжилд нөлөөлөх улс төр, эрх зүйн хүчин зүйлсийг тогтвортой хөгжлийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд, суурь зарчмуудаас ургуулан сонгуулийн тогтолцооны хувилбарыг тодорхойлох боломжтой гэж үзлээ.

2.4. Судалгааны асуулт

Хүснэгт 1. Судалгааны асуулт 1

	Өгөгдөл	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж
1.	Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлалын баримт бичигт	НҮБ-ын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хангасан, эсэх	1.Эдийн засгийн өсөлт 2.Байгаль орчныг хамгаалах бодлого 3. Нийгмийн тэгш байдлыг тогтоох

Хүснэгт 2. Судалгааны асуулт 2

	Өгөгдөл	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж
1.	1992-2016 оны сонгуульд оролцсон намуудын мөрийн хөтөлбөрт	Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлал зорилтууд тусгагдсан, эсэх	1.Эдийн засгийн өсөлт 2.Байгаль орчныг хамгаалах бодлого 3. Нийгмийн тэгш байдлыг тогтоох
2.	1992-2016 оны төр, засгийн шийдвэрт		

Хүснэгт 3. Судалгааны асуулт 3

	Өгөгдөл	Шалгуур үзүүлэлт
1.	Сонгогч саналаа өгөхдөө	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалыг анхаардаг, эсэх Сонгуулийн өдрийн өмнөх сар, жилүүдэд нийгэм, засаглал, эдийн засаг, оюуны амьдралд гарсан эрс өөрчлөлтийг анхаардаг, эсэх

2.5. Судалгааны таамаглал:

1. Сонгуулийн мөрийн хөтөлбөр, төр засгийн шийдвэрүүд нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай харилцан уялдаатай байдаггүйгээс өнөөгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны хямрал гарч байна.
2. Сонгогчийн тогтвортой хөгжлийн талаарх мэдлэг, мэдээлэл хангалтгүйгээс тэдний сонголтод нөлөөлж байна.
3. Сонгогчийн тогтвортой хөгжлийн талаарх итгэл үнэмшил хангалтгүй байдалд улс төрийн намууд зөвхөн сонгуульд ялах ойрын зайн бодлого дэвшүүлдэг.
4. **Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалыг тогтвортой байлгахад сонгуулийн холимог хувилбар сонгох нь оновчтой.**

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

3.1. Судалгааны төрөл, түүний зорилго

Монгол Улсад сонгуулийн тогтолцооны хувилбарын аль нь тохиромжтойг тодорхойлон үнэлэхдээ чанарын буюу тодорхойлох (дискриптив) судалгааны аргаар шалгана. Ингэхдээ 1990-2020 оны сонгуульд оролцсон намуудын мөрийн хөтөлбөр, сонгуульд ялсан намын УИХ, Засгийн газрын шийдвэрт дүн шинжилгээ хийх болно.

3.2. Судалгааны эх олонлог, түүвэр

Эх олонлог нь мэдээлэл цуглуулах объект буюу НҮБ-аас гаргасан тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичиг, 1990-2016 оны сонгуульд оролцсон намуудын мөрийн хөтөлбөр, сонгуульд ялсан намын УИХ, Засгийн газрын шийдвэрт тогтвортой хөгжлийн үзэл баримтлал тусгагдсан, эсэх зөрүүг шинжилнэ.

Зөрүү бий болоход нөлөөлж буй хүчин зүйлсэд:

1. Улс төрийн намуудын төлөвшил
2. Сонгогчийн итгэл үнэмшил

3.3. Судалгааны хэмжүүр

Судалгааны өгөгдлийг шалгахдаа дараах шалгуур үзүүлэлтүүдийг удирдлага болгоно.

Хүснэгт 4. Судалгааны асуултыг шалгах шалгуур үзүүлэлт

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг тодорхойлсон Монгол Улсын бодлогын баримт бичиг гарсан, эсэх	Сонгуульд оролцсон намын мөрийн хөтөлбөрт тусгагдсан, эсэх	Сонгуулийн дараа төр, засгийн шийдвэрт тусгагддаг, эсэх	Сонгогч хөгжлийн үзэл баримтлал, бодлогыг ухамсарлан саналаа өгдөг, эсэх
---	--	---	--

3.4. Өгөгдөл цуглуулах

Баримт бичгийн судалгаа: Үүнд намуудын мөрийн хөтөлбөр, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, холбогдох хууль тогтоомж

Анкетын судалгаа: Сонгогчийн итгэл үнэмшлийг тандах санал асуулга

Хүснэгт 5. Иргэдээ авах түүврийн мэдээлэл

№	Сонгууль	Төрсөн он (Сонгуулийн өдрөөс өмнө төрсөн)
	1990	
	1992	-1974
	1996	-1978
	2000	-1982
	2004	-1986
	2008	-1990
	2012	-1994
	2016	-1998
	2020	-2002
Нийт	“Ковид-19” -тэй холбоотойгоор google.doc ашиглан санал авна.	

Өгөгдөл цуглуулахад тулгарсан бэрхшээл: “Ковид 19”-ын хөл хориог 2020 оны арваннэгдүгээр сарын 11-нээс эхлүүлсэн ба иргэдээс биечлэн санал асуулга авах, Төв номын санд архивын бичиг баримттай танилцах, улс төрийн намуудын төлөөлөлтэй ярилцлага хийх зэрэгт хүндрэл учирсан болно. Мөн энэ жил Ерөнхийлөгчийн сонгуулийн жил тул иргэд, төрийн байгууллагын албан тушаалтнуудаас ямар зорилгоор авч байгаа, тандан судалгаа хийж байна гэх зэргээр хардах, буруушаах явдал гарсан.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ӨГӨГДЛИЙН БОЛОВСРУУЛАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Өмнөтгөл

Энэ судалгаанд Монгол Улсын бүх цаг үеийн түүхийг дурдахгүй ч 1924 оны Үндсэн хуулийг баталснаас эхлэн ардчилсан нийгэмд шилжсэн 1990 он хүртэлх хугацааны манай улсын хөгжлийн философи, үзэл баримтлалыг товчхон дурдъя.

1924-1940 он хүртэлх 20 жилд 1911, 1921 онд хувьсгал хийж олж авсан тусгаар тогтнолоо хамгаалахын тулд төр засгийн үйл ажиллагаа явж ирсэн байна. Тодруулбал, сонгосон замынх нь эхний шат нь үндэс угсаагаа аварч, эрдэм соёлыг хөгжүүлэн, эдийн засгийн амьдралаа гадаадын мөлжигчдөөс чөлөөлж, хөгжлийн хувьд өөрийн гэсэн бүхнээ хийх эхлэлийг тавихад оршиж байв⁹. Монгол Улсын эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах ажил 1922 онд эхэлж, Засгийн газрын шийдвэрээр Б.Цэрэндорж, Ж.Цэвээн, О.Жамьян нарын бүрэлдэхүүнтэй байгуулжээ. Тэд “Эдийн засгийн үндсэн бодлого” хэмээх баримт бичиг боловсруулсныг 1923 оны наймдугаар сард хуралдсан МАН-ын их хурлаар баталсан билээ¹⁰. Харин 1940 оноос эхлэн тухайн үеийн төр засгийн гол удирдлага МАХН Их Хурлаараа Монгол Улс хөрөнгөтний биш, хөгжлийн замыг сонгосон буюу шинээр баталсан Үндсэн хуульдаа: Тус хуулийн нэгдүгээр зүйлд “Бүгд Найрамдах Монгол Ард Улс болбоос эзэрхэг түрэмгий ба феодалын дарлалыг устгасан, цаашид нийгэм журамд дэвшин орохын учир улс орон юугаа хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангаж бүхий хөдөлмөрчин (малчин, ажилчин, сэхээтэн) ардын тусгаар тогтносон улс мөн болно” гэж заасан. Урт хугацааны хөгжлийн талаарх үзэл баримтлал нь хөрөнгөтний бус хөгжил гэж тодорхойлогдож байв. Энэхүү хөгжлийн философи, үзэл баримтлалыг зөв эсвэл буруу байсныг энд дурдахгүй бөгөөд гагцхүү өмнөх нийгэмд бид өөрсдийн хөгжлийн философитой, үзэл баримтлалтай, түүндээ хүрэх зорилт, төлөвлөгөөтэй явж байсан гэдгийг хэлэх ёстой.

Ялангуяа энэ цаг дор манай улс өөрийн онцлог бүхий хөгжлийн замыг сонгохыг “хүссэн ч” олон улсын байдал түгшүүртэй, мөн л тусгаар тогтнолын байдал “эмзэг” хэвээр байсан тул ЗХУ-тай найрсаг, социалист хөгжлийн замыг тодорхойлсон гэдэгтэй маргахгүй байх. 1960 оны Үндсэн хуульд “БНМАУ бол ажилчид, хоршоолсон ардууд (малчин тариачид), хөдөлмөрч сэхээтний социалист улс бөгөөд түүний үндэс нь ажилчин анги, хоршоолсон ардын холбоо мөн” хэмээн заасан. Дэлхий II дайн дуусаж, дэлхийд социалист улс орнуудын тоо ихсэж, хамтын холбоо болтлоо өргөжсөн тул Монгол Улс хөгжлийн үзэл баримтлалаа социализмын чиг баримжаатай гэж илүү тодотгон тодорхойлсон.

Урт хугацааны хөгжлийн бодлогыг тухайн цаг үеийн эрх баригчид баримт бичиг болгож баталдаг. 1921-1990 он хүртэл Монгол Улсын төрийн байгууллын үндэс нь нэг намын тогтолцоотой байсан тул МАХН-ын дөрвөн удаагийн мөрийн

⁹ Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус). 2017. х.46

¹⁰ БНМАУ хөрөнгөтний биш хөгжлийн төлөө тэмцэлд (1925-1940). Баримт бичгийн эмхэтгэл. Улсын хэвлэл. УБ., 1956.

хөтөлбөрийг (программ) бодлогын баримт бичиг гэж тооцож болно. Эдгээр мөрийн хөтөлбөрт тавигдсан зорилтыг хэрэгжүүлэхээр нам, засгийн шийдвэр гардаг байв. Жишээлбэл, 1966 онд хуралдсан МАХН-ын XV Их Хурлаар дөрөвдүгээр программыг баталсан ба үүгээр хөдөө аж ахуйн улс орноос аж үйлдвэржсэн орон болох зорилт дэвшүүлж, энэ дагуу олон арван үйлдвэр, хоршоо байгуулагдсан. Жишээлбэл, 1980 оны эхээр Монгол Улсын үйлдвэрлэлийн хөгжлийн схемийг 2000 он хүртэл, эрчим хүчний хангамжийг хөгжүүлэх схемийг 2005 он хүртэл төлөвлөж байжээ¹¹.

Тухайн жилүүдэд ард түмэндээ нийгмийн халамж, үйлчилгээний хувьд ээлтэй байсан ч эдийн засгийн бодлого талаасаа алдагдалтай байсан нь 1980 оны сүүлчээр социалист улс орнуудад гарсан өөрчлөн байгуулалтын үйл явцаас харж болно. Хэрэв тухайн үе буюу 1980 оны сүүлч 1990 оны эхэн үед эдийн засгийн хөгжлийн бодлогын хувьд алсыг харсан бол хэт уналтын түвшинд очихгүй ч байх боломжтой гэж зарим судлаач үзсэн байдаг¹². Гэхдээ манай улсын газарзүйн байршил, хоёр том хөршийн дунд оршдог, хүн ам цөөн зэрэг хүчин зүйлс, мөн л тусгаар тогтнолын хувьд “эмзэг” байдал арилаагүй түүхэн цаг үе байсныг мартаж болохгүй. 1940-1990 он буюу тогтсон хөгжлийн философитой байсан хугацаанд дэлхийн “улс төрийн газар зүйн байршил”-д бие даах, хараат бус байх нь нэлээд төвөгтэй юм.

Мөн дурдсан хугацаанд явуулж ирсэн хөгжлийн үзэл баримтлал, бодлого нь хүн амыг эрүүлжүүлэх, боловсролын тэгш, хүртээмжтэй байдлыг бий болгож чадсан юм. Үүний үр дүнд 1990 оны нийгмийн шилжилтийг харьцангуй тайвнаар (эмх замбараагүй байдал, хүний амь хохироолгүйгээр), эдийн засгийн уналтыг хүн амыг өлсгөлөнд нэрвэгдүүлэхгүйгээр хийж чадахад нөлөөлсөн нэг хүчин зүйл гэж дүгнэж байна.



¹¹ Монгол Улсын хөгжлийн бодлого, үзэл баримтлал: хувьсал, өөрчлөлт (XX зуун). 2008. х.223

¹² П.Лувсандорж. Монгол улсын эдийн засгийн шилжилт, хөгжлийн асуудлууд. Бүтээлийн чуулган- I боть.

4.1. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг тодорхойлсон Монгол Улсын бодлогын баримт бичиг гарсан, эсэх

Энэ хэсгийн судалгааны зорилго Монгол Улс тухайн сонгуулийн жилүүдэд урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалтай байсан, эсэх, судалгааны гол үзэл баримтлал болох НҮБ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай нийцэж буй, эсэхийг тодруулахад оршино.

1990-1992 оны сонгуулийн жил:

1980 оны сүүлчээр социалист гэгдэх улс орнуудад гарсан өөрчлөн байгуулалтаар бидний хөгжлийн зорилго байсан социализм мухардалд орсон байлаа.

Хөгжлийн үзэл баримтлалын хувьд Германы суут сэтгэгч Г.В.Гегелийн диалектик аргачлал бүхий түүхийн детерминист аргаар хүн төрөлхтний хөгжлийн үе шатыг авч үзсэн байдаг. Мөн Германы суут сэтгэгч К.Маркс, Ф.Энгельс нар нийгмийн хөгжлийн социалист загварыг тодорхойлж гаргасан.

1990 онд социалист системийн улс орнуудад гарсан хамгийн гол хямрал нь эдийн засгийн хувьд баримталж байсан бодлогын буруугаас уналтад орсонтой холбоотой гэж судлаачид үздэг.

Монгол Улс 70-аад жилийн турш хөгжлийн үзэл баримтлал гэж зорилго, зорилгоо тодорхойлж, төлөвлөж байсан социалист нийгэм оршин тогтнох боломжгүй нөхцөлд цаашид яах вэ гэдэг асуулт тухайн үеийн төр засаг иргэдэд тулгарсан.

1989 оны сүүлч 1990 оны эхээр үүссэн нийгэм, улс төрийн нөхцөл байдалд өөрчлөлт гарав. 1989 оны арванхоёрдугаар сарын 10-нд МоАХ-ноос тухайн үеийн эрх баригчдад тавьсан өргөх бичгийн агуулгыг ерөнхий зохицуулагч С.Зориг: Манай өргөн барих бичгийг Мөрийн хөтөлбөр гэж ойлгож болно, бид аль алиныг нь нарийвчлан боловсруулна гэж хариулж байжээ¹³. Өргөх бичгийн агуулгаас дурдахад Хүний эрхийн түгээмэл тунхаглалд тодорхойлсон зарчмыг төр, засаг, намын үйл ажиллагаанд дээдлэх, байнгын ажиллагаатай парламент, сонгуулийн системийг өөрчлөх тухай байлаа. Мөн дараа нь болсон цуглаанд МоАХ-ны лидерүүдийн хэлж байсан илтгэлээс дурдахад: МоАХ бол өөрчлөн байгуулалтыг гүнзгийрүүлж улс орноо хүний эрхийг дээдэлсэн, хүнлэг энэрэнгүй, ардчилсан улс болгох зорилготой байгууллага”¹⁴ хэмээн тодорхойлж байв.

Түүнчлэн 1989 оны арванхоёрдугаар сарын сүүлчээр Ардчилсан социалист хөдөлгөөн бий болж, Монголын нийгмийн байгууллыг өөрчлөх саналыг анх дэвшүүлж тунхаг гаргасан байдаг. Энэ тунхгийн гол агуулга нь монгол хүн өөрийн хүч оюуныг дайчлаад өөр хэнээс ч дутахгүй явж болох орчныг бий болгоё. Ардчилсан социализмыг бий болгохыг уриалж байна гэжээ¹⁵. Ийнхүү улс төрийн холбоо, хөдөлгөөн бий болсоор 1990 оны хоёрдугаар сарын 18-нд МоАХ Их Хурлаараа МоАН байгуулснаа зарласан. Ардчилсан Холбооны мөрийн хөтөлбөрт “Жинхэнэ социализм нь хөгжингүй капитализмыг бодвол хүн төрөлхтний соёл иргэншлийн дэвшил цэцэглэлтийн илүү өндөр үе шат мөн” гэсэн онолыг тухайн үед үзэл баримтлалаа болгож байсан нь нэг

¹³ Т.Лхагваа нар. Ардчиллын замнал: алдаа-оноо, сургамж-сорилт. (түүхэн товчоо). 2019 х.

¹⁴ Мөн тэнд

¹⁵ Яагаад ардчилал гэж?.....2012.х.23

талаас өмнөх тогтолцооны залгамж халааг үргэлжлүүлэх эрмэлзэл, нөгөө талаас хөгжлийн бодлогын талаар суурь мэдлэг, туршлагын хувьд шинэхэн байсанд болов уу.

1990 оны дөрөвдүгээр сарын 8-нд МоАН-ын анхдугаар их хурал хуралдав. Энэ хурлаараа намын мөрийн хөтөлбөр, дүрмийг баталсан. Эдгээр баримт бичгийн агуулга нь энэрэнгүй ардчилсан нийгэм байгуулах явдал бөгөөд өмчийн олон хэлбэрийг зөвшөөрөх зэрэг үзэл санааг багтаасан байлаа.

1990 оны гуравдугаар сарын 31-нд МСДН их хурлаа хийж, намын мөрийн хөтөлбөр, дүрмээ баталсан. Мөрийн хөтөлбөр, дүрэмд МоАН-тай адил хүний эрх, эрх чөлөөний үзэл санаа багтаж, эдийн засгийн чөлөөт зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх зэргээр зорилгоо тодорхойлсон байна.

1990 оны гуравдугаар сарын 11-нд МҮДН-ыг байгуулж, тавдугаар сард их хурлаа хийсэн. Мөрийн хөтөлбөрт МҮДН-ын эдийн засгийн үзэл баримтлал, Хөгжил дэвшлийн тухай, Монгол оршихуйн ухаан гэсэн агуулгыг багтаан, Монгол оронд хүмүүнлэг, ардчилсан, иргэний журамт нийгэм, нийгмийг үндэсний хөгжил дэвшлийн жам ёсонд тулгуурласан нам байхаа тодорхойлсон байна.

Ийнхүү шинээр ардчиллын гэгдэх улс төрийн холбоо, намууд бий болж, өөр өөрсдийн намын дүрэм, мөрийн хөтөлбөрөө тодорхойлсон бөгөөд 70-аад жил төр засгийг жолоодон удирдаж байсан МАХН энэ цаг үед хэрхэн намынхаа мөрийн хөтөлбөр, дүрэмд өөрчлөлт оруулсан талаар судлах нь зайлшгүй юм. 1989 оны арваннэгдүгээр сараас К.Зардыхан доктор түүх, философи, эдийн засаг, социологи, олон улсын харилцааны чиглэлийн эрдэмтдийг судалж, 15 эрдэмтний баг бүрдүүлж, намын шинэ дүрэм, хөтөлбөр боловсруулахаар болсон байна. Энэ талаар тухайн багийн бүрэлдэхүүнд байсан хүний дурсамжаас толилуулбал:

“Монгол Ардын Нам /МАХН/-ын программын тунхаглал”, “Монгол Ардын Намын дүрэм” гэсэн хоёр баримт бичгийг бэлэн болгож, “Үнэн” сонины 1990 оны гуравдугаар сарын 8-ны өдрийн дугаарт нийтлүүлэв. Намын программын тунхаглалд хүнийг нийгмийн бүх асуудлын төвд тавьж, тал бүрээр хөгжүүлэх зорилтыг анх удаа цогц байдлаар дэвшүүлсэн бөгөөд ийм ч учир уг тунхаглал “Хүнлэг, энэрэнгүй нийгмийн бодлого” гэсэн хэсгээр эхэлсэн. ...намаас баримтлах эдийн засгийн бодлого нь дэлхийн аж ахуйн хөгжил, олон улсын хөдөлмөрийн хуваарь, шинжлэх ухаан, техникийн дэвшлийн орчин үеийн ололтод уян хатан зохицох чадвартай, өмчийн олон хэлбэрт тулгуурласан, өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулах чадавхтай, нийгэм, хамт олон, хувь хүний сонирхлоос үндэслэсэн төрийн зохицуулалт бүхий зах зээлийн эдийн засгийн өндөр үр ашигтай цогцолбор бий болгоход оршино” гэж заав.

Доктор. Б.Батхишиг

1990 оны гуравдугаар сард БНМАУ-ын АИХ-ын XI дэх удаагийн VIII чуулганаар 1960 онд батлагдан үйлчилж буй Үндсэн хуулийн 82 дугаар зүйлд “БНМАУ-ын иргэд **хүмүүнлэг, ардчилсан социалист нийгэм байгуулах зорилт, ард түмнийхээ язгуур эрх ашиг, эв нэгдэлд нийцсэн мөрийн хөтөлбөр, дүрэм бүхий улс төрийн нам**, олон нийтийн байгууллагад эвлэлдэн нэгдэх эрхтэй...” гэж нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Хэдийгээр социалист нийгмийн задрал хүчтэй явагдаж

байсан цаг үе ч хөгжлийн үзэл баримтлалын хувьд социалист нийгэм байгуулах зорилгоо өөрчлөөгүй байлаа. Нийгмийн шилжилтийн үр дүнд хөгжлийн үзэл баримтлал, бодлого өөрчлөгдөх нь гарцаагүй боловч өмнө хэрэгжүүлж ирсэн төрийн бодлогын залгамж байдал алдагдаж болохгүй гэж тухайн үеийн удирдлагууд үзсэн болов уу.

Мөн тухайн үед улсынхаа цаашдын хөгжлийн философио тодорхойлж, намуудыг хариуцлагажуулсан заалтыг Үндсэн хуульд тусгасан нь хөгжлийн философийн арга зүйн хувьд зөв байсан гэж дүгнэж болно. Энэ зохицуулалтыг 1992 оны Үндсэн хуульд оруулаагүй. Харин 2019 оны тус хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллахыг намуудад дахин үүрэг болгосон заалт тусгасан.

Харин урт хугацааны энэхүү хөгжлийн үзэл баримтлалыг бие даасан бодлогын баримт бичигт тусгаагүй тул уг ардчилсан социалист нийгмийн зорилт, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зохицуулалт байхгүй.

1992-1996 оны сонгуулийн жил:

Энэ цаг үед Монгол Улс ардчилсан шинэ Үндсэн хуулиа баталж, нийгмийн цоо шинэ тогтолцоонд шилжсэн. Шинэ Үндсэн хуульд “эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” гэж тунхагласан.

Их цаазын буюу 1992 оны Үндсэн хуулийн төсөл хэлэлцэж байх цаг үед АИХ-ын депутатууд хүмүүнлэг, иргэний нийгэм гэдгийг ямар агуулгаар оруулж ирснийг тодруулж, мөн “нүүдлийн соёл иргэншлийг хадгалах, шударга нийгмийг байгуулах” гэж зорилгоо тодорхойлж хэмээн саналууд гаргаж байжээ¹⁶. Төсөл боловсруулсан ажлын хэсгээс: Үндсэн хуулийн зорилгыг тодорхойлохдоо программчилсан шинжээс татгалзсан. Ямар нэгэн улс төрийн нам, үзэл бодлын философи дээр суурилагагүй гэж тайлбар өгсөн байдаг. Тодруулбал 1991 оны долдугаар сард Ардын эрх сонинд Их цаазын төслийг ард нийтээр хэлэлцүүлэх явцад иргэдээс тавьж буй саналтай холбоотойгоор Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын нарийн бичгийн дарга Б.Чимэдтэй хийсэн ярилцлагаас сийрүүлбэл¹⁷: *Иргэдээс Монгол Улсын туулж өнгөрүүлсэн түүхэн замнал, ирээдүйн хандлагыг дүгнэн хэлэх шаардлагатай биш үү гэсэн санал нэлээд ирж байна. Таны хариулт? Б. Чимэд: Иргэд улс орон маань одоо хаашаа явж байна вэ хэлээд өгөөч гэх нь цөөнгүй байна. Гүн ухааны асуулт юм. Энэ асуудлыг Үндсэн хуулиар шууд зааж өгөх оновчтой бус гэж үзсэн. Гэхдээ төр иргэний харилцаанд суурилсан хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийн тухай үзэл баримтлалд суурилж, энэ Үндсэн хуулийг баталж байна гэсэн агуулгаар асуултад хариулжээ.*

Тухайн үед урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалыг өмнөх тогтолцооны “гажуудал” гэх хандлага маш хүчтэй байсан тул түүнийг тодорхойлох, зорилт болгон дэвшүүлэх зэрэг асуудал орхигдсон гэж дүгнэж байна.

¹⁶ АИХ-ын Их цаазын төсөл хэлэлцсэн протоколоос

¹⁷ Б.Чимэд. Үндсэн хуулийн үзэл баримтлал. 2004, 2016, 2017 он. эмхэтгэл. х.40

Шинэ Үндсэн хуулийн дагуу УИХ-ын анхны сонгууль болж МАХН ялсан. Энэ цаг үед дэлхийн нийтийн чиг хандлагад мөн урт хугацааны хөгжлийн нэгдмэл үзэл баримтлал хэрэгтэй гэдэгт улс орнууд нэгдэж, тодорхой алхам хийсэн байна.

1992 онд НҮБ-ын Рио-гийн “Байгаль орчин ба Хөгжил” Даян Дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалтад Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүтэй төлөөлөгчид оролцон олон улсын хөгжлийн хамтын нийгэмлэгт анх удаа нэгдэн орсон түүхтэй. Тус дээд хэмжээний чуулга уулзалтаар тогтвортой хөгжлийн тунхаглалын 27 зарчмыг баталж, НҮБ-ын гишүүн орон бүр XXI зууны өөрсдийн Тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрөө боловсруулах үүрэг амлалт авсан.

Энэ амлалтаас бараг дөрвөн жилийн дараа буюу 1996 оны тавдугаар сард 1990 оноос хойш гарсан урт хугацаатай хөгжлийн бодлогын эхний бие даасан баримт бичиг болох Улсын Их Хурлын (УИХ) 26 дугаар тогтоолоор Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлал (МУХҮБ) нэртэйгээр баталжээ.

Уг бодлогын баримт бичигт Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлалыг тодорхойлохдоо: “*Монгол Улсын 15-25 жилийн хөгжлийн хэмжүүр нь: өөрөө өөрийгөө нөхөн хангах чадвартай, эдийн засгийн тогтвортой хөгжил*” гэдгийг тодорхойлоод зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих бодлогын чанартай өөрчлөлт хийснээр шинэчлэлийн үйл явц түргэсэж, үйлдвэрлэлийн уналт зогсох хандлагатай болж, эдийн засагт тогтворжилтын зарим эхлэл гарч, хүн амын нийгмийн хамгааллын шинэ тогтолцоог бүрдүүлж эхлээд байна гэж дүгнэсэн байна.

Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал бол ойрын ирээдүйд улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, хүний чөлөөт хөгжил, нийгмийн дэвшлийг хангах талаар төрөөс баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлсон баримт бичиг мөн гэж заасан нь мөн л өмнөх социалист нийгмийн мөн чанараас шалтгаалан урт хугацааны гэдэг үгнээс татгалзаж, ойрын ирээдүй гэдэг нэр томъёог хэрэглэсэн гэж үзэж болохоор байна.

Хүснэгт 6. Тогтвортой хөгжлийн үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан байдал

Шалгуур үзүүлэлт	Хангасан байдал (зүйл, заалтаар түүвэр хийх)
Эдийн засгийн өсөлт	өөрөө өөрийгөө нөхөн хангах чадвартай, эдийн засгийн тогтвортой хөгжил;
Байгаль орчныг хамгаалах	тогтвортой хөгжил, байгаль орчны зохицолдоо;
Нийгмийн тэгш байдлыг хангах	хүний хөгжил, амьдралын чанар;

Гэхдээ энэ бодлогын баримт бичигт НҮБ-ын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал болох Хөгжлийн хөтөлбөрийн 27 зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн зэргийг харьцуулсан, эсэх талаар судалгааны мэдээлэл алга. Хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүнгийн талаар ерөнхий заасан тул тунхгийн шинжтэй болсон гэж дүгнэлээ.

1996-2000 оны сонгуулийн жил:

Энэ цаг үе бол шинэ залуу улс төрийн хүчин болох ардчилсан гэгдэх намууд сонгуульд ялсан, тэдний бодлого, мөрийн хөтөлбөр хэрэгжих жилүүд байлаа.

1996 оны тавдугаар сард баталсан Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлал хэрэгжиж байгаад 1998 оны тавдугаар сард Засгийн газрын 82 дугаар тогтоолоор Монгол Улсын XXI зууны Тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөр баталсан байна. Өмнө нь баталсан Хөгжлийн үзэл баримтлалыг яагаад өөрчлөх болсон талаар судалгаа, мэдээлэл алга.

Хүснэгт 7. Тогтвортой хөгжлийн үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан байдал

Шалгуур үзүүлэлт	Хангасан байдал (зүйл, заалтаар түүвэр хийх)
Эдийн засгийн өсөлт	Байгаль экологийн даацад нийцсэн эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах
Байгаль орчныг хамгаалах	Байгаль орчны доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх
Нийгмийн тэгш байдлыг хангах	Ядуурал, ажилгүйдлийн түвшин бууруулах

Судалгаа хийх явцад энэ баримт бичгийн эх хувилбарыг олж чадсан. “Ковид-19” цар тахлын хорио цээртэй холбоотойгоор номын сан, архив ажиллахгүй байна.

2000-2004 оны сонгуулийн жил:

Энэ сонгуулийн жилд МАХН засгийн эрхийг барьсан.

Дэлхийн 189 орны төр, засгийн тэргүүн оролцсон НҮБ-ын Мянганы дээд хэмжээний уулзалтаар 2000 оны есдүгээр сард “Мянганы тунхаглал” баримт бичгийг баталсан. Энэхүү баримт бичигт 2015 он хүртэлх хугацаанд шийдвэрлэвэл зохих ядуурал, эрүүл мэнд, боловсрол, хүрээлэн буй орчин, хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийн хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг багцлан найман зорилго, 18 зорилтын 48 шалгуур үзүүлэлтэйгээр дэвшүүлэн баталсан билээ. Тус Мянганы зорилттой шууд уялдах бодлогын баримт бичиг энэ сонгуулийн жилүүдэд гараагүй.

Харин УИХ-аас 2001 онд Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг баталжээ. Оршил хэсэгтээ “...эдийн засаг, нийгмийн хөгжлийн нутаг дэвсгэрийн тэнцвэргүй байдлыг бууруулах явдал Монгол Улс XXI зууны тогтвортой хөгжлийн замд дэвшин орох нэн чухал угтвар нөхцөл мөн” гэжээ. Энэ үзэл баримтлалын хүрээнд 2003 онд Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги (2010 хүртэл), Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг”, мөн онд Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль тус тус гарчээ.

Хүснэгт 8. Тогтвортой хөгжлийн үндсэн шалгуур үзүүлэлтийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал хангасан байдал

Шалгуур үзүүлэлт	Хангасан байдал (зүйл, заалтаар түүвэр хийх)
Эдийн засгийн өсөлт	Эдийн засгийг бүсчлэх замаар өсөлтийг дэмжих
Байгаль орчныг хамгаалах	Эдийн засгийн бүсчлэл хийхээр байгаль хамгаалах, нөхөн сэргэх боломжтой гэж үзсэн
Нийгмийн тэгш байдлыг хангах	Эдийн засгийн бүсээ даган ядуурал, ажилгүйдэл буурна гэж үзсэн

2004-2008 оны сонгуулийн жил:

Энэ сонгуулийн жилд МАХН, ардчилсан хүчний гэгдэх намуудын хамтарсан Засгийн газар байгуулагдсан онцлогтой.

Монгол Улсын Үндэсний хөгжлийн хөтөлбөр (2005), “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”, “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт” (2005) хөтөлбөр зэрэг тус тусдаа баримт бичгүүдийг баталсан. 2008 оны нэгдүгээр сард НҮБ-ын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг баталсан.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүнг 2007-2015 онд Мянганы хөгжлийн зорилтыг хангах, эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх, 2016-2021 онд мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих гэсэн хоёр үе шаттай хамтатган авч үзсэн болно.

Хүснэгт 9. Тогтвортой хөгжлийн үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан байдал

Шалгуур үзүүлэлт	Хангасан байдал (зүйл, заалтаар түүвэр хийх)
Эдийн засгийн өсөлт	зах зээлийн эдийн засагт суурилсан хөгжил эрчимтэй, тогтвортой байх;
Байгаль орчныг хамгаалах	уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон арга чадавхыг бий болгох, экосистемийн тэнцвэрт байдлын алдагдлыг зогсоох, хамгаалах замаар хөгжлийн тогтвортой орчин бий болгоно.
Нийгмийн тэгш байдлыг хангах	“Монгол хүний амьдралын чанар”-ыг тасралтгүй дээшлүүлж, 2015 он гэхэд Мянганы хөгжлийн зорилтуудыг бүрэн биелүүлж, хүний хөгжлийн индексийг 0.83-д хүргэх бодлого баримтална.

2008-2012 оны сонгуулийн жил:

Сонгуулийн “эгзэгтэй” үр дүнгийн улмаас МАХН, ардчилсан хүчний намуудын нэгдэл болох АН-ын хамтарсан төр, засаг бий болсон.

2008 онд УИХ-аас баталсан Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг (ҮХЦБ) үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Их Сургууль (МУИС)-ийн дэргэдэх Эдийн засгийн судалгааны хүрээлэнгээс 2014 онд гаргасан “Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн харьцуулсан судалгаа”-нд Монгол Улс Үндэсний хөгжлийн цогц бодлогыг 2007-2008 онд боловсруулсан боловч эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэх, хянах, хариуцлага тооцох механизм байхгүй байсан учраас тус хөтөлбөр тунхгийн шинж чанартай хэвээр үлдсэн гэж дүгнэжээ¹⁸.

2012-2016 оны сонгуулийн жил:

Ардчилсан нам энэ сонгуулийн үр дүнд олонх болсон.

Бразилын Рио де Жанейро хотноо НҮБ-аас 2012 оны арванхоёрдугаар сард зохион байгуулсан дэлхийн дээд хэмжээний уулзалт РИО+20 чуулганаар 2012 оноос хойш дэлхийн улс орнуудын баримтлах хөгжлийн бодлогыг “Тогтвортой хөгжил” гэж тодорхойлсон. Энэхүү чуулганаас өнөө болон хойч үеийнхний тогтвортой ирээдүйг баталгаажуулахын тулд эдийн засаг, нийгэм болон байгаль орчны харилцан уялдаа, нөлөөллийг цогцоор нь авч үзэх шаардлагатайг онцолж, “Бидний хүсэж буй ирээдүй” баримт бичгийг баталсан. 2015 оны есдүгээр сард АНУ-ын Нью-Йорк хотноо хуралдсан НҮБ-ын Ерөнхий ассамблейн 70 дугаар чуулганаар Дэлхийн 193 орны удирдагчид 2030 он хүртэлх дэлхий нийтийн хөгжлийн хөтөлбөр болох Тогтвортой хөгжлийн зорилтуудыг батлав. Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ) нь Мянганы хөгжлийн зорилтын үргэлжлэл бөгөөд хоорондоо харилцан хамааралтай тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилт нь хэнийг ч орхигдуулалгүй, ядуурлын бүх хэлбэрийг устгаж, эх дэлхийгээ хамгаалж, хүн төрөлхтнийг тайван амгалан, хангалуун, эрх тэгш амьдрах боломжоор хангах дэлхий нийтийн зорилго юм.

Манай улс НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн 2030” хөтөлбөрт нийцүүлэн Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хөтөлбөрийг баталсан. Үүнийг боловсруулсан ажлын хэсгийн тайланд дурдсанаар: Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх Үндсэн хуулийн заалтыг иш үндэс болгон Монгол Улс 2030 онд эдийн засгийнхаа өсөлтөөр бүс нутгаа тэргүүлж, нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, даяаршсан зах зээлд тогтвортой өсөж байгаа олон салбартай, нээлттэй эдийн засагтай, нийгмийн хүрээнд орлогын тэгш бус байдлыг арилгаж, ядуурлаас бүрэн ангид, чинээлэг дундаж давхарга давамгайлсан, улс орноо алсын хараатай бодлогоор хөгжүүлдэг хариуцлагатай ардчилсан засаглалтай, хөгжих боломжийг иргэн бүрд ижил олгож, бүтээлч үйл ажиллагааг дэмждэг, шударга өрсөлдөөнд тулгуурласан бизнесийн тунгалаг орчинтой, унаган байгаль, экологийн тэнцвэрийг хадгалсан ногоон хөгжлийг эрхэмлэсэн улс болгохоор Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулсан гэсэн байна.

2016-2020 оны сонгуулийн жил:

Улс төрийн ууган нам МАН (МАХН) сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулав. Монгол Улсын “Алсын Хараа-2050”-ыг баталсан. Ингэхдээ Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны хоёрдугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг тухайн үед хүчинтэй байгаа

¹⁸ Б.Түвшинтөгс, Д.Эрдэнэбулган, 2014.

бодлогын баримт бичгүүдийг үнэлсэн байна¹⁹. Өмнөх “Монгол Улсын тогтвортой хөгжил-2030”-ыг сайн хэрэгжүүлж амжаагүй байхад нь өөрчилжээ.

Бүлгийн дүгнэлт: Монгол Улс 1990 оноос хойш зохион байгуулсан парламентын сонгуулийн үр дүнд байгуулагдсан АИХ, УБХ, УИХ, Засгийн газрууд улсынхаа урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалыг тодорхойлж, үүний залгамж халаа, тогтвортой байдлыг хангах бодлогын ямар баримт бичиг гаргаж байсан талаар түүхчлэх аргаар товч харууллаа. 1990, 1992 оны сонгуулийн жилүүдэд нийгмийн шинэ тогтолцоонд шилжиж буйтай холбоотойгоор урт хугацааны үзэл баримтлалын шинжтэй зорилгыг Үндсэн хуульдаа тусгаж өгсөн байна. Харин энэ цаг үеүдэд урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалыг бодлого болгон тодорхойлох, зорилт дэвшүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээ болон хүрэх үр дүнг нь нэгдмэл байдлаар авч үзсэн баримт бичиг гаргасангүй.

Анхны урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалыг илэрхийлсэн бодлогын баримт бичгийг 1996 онд баталсан. Гэхдээ энэ баримт бичиг найман хуудас бүхий, хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх дүнгийн талаар ерөнхий, тунхгийн шинжтэй байсан, өөрөөр хэлбэл, өмнө нь дурдсан 1992 оны Рио-гийн хурлаас авсан амлалтаа биелүүлэх төдий ажил хийжээ гэж дүгнэлээ. 1996 оны сонгуулиар цоо шинэ улс төрийн нам төр, засгийн бодлого хэрэгжүүлэхдээ уг 1996 оны хөгжлийн бодлогын баримт бичгийг 1998 онд хүчингүй болгож, шинээр Тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөр гаргасан байна. Өмнөх төр, засгийн гаргасан хөгжлийн үзэл баримтлал үргэлжилсэнгүй ба ямар үндэслэлээр өөрчилсөн шалтгаан тодорхойгүй үлджээ.

Дараагийн 2000-2004 оны сонгуулийн жилд МАХН нь дахин төр, засгийн бодлого хэрэгжүүлэхдээ өмнөх засгийн гаргасан хөгжлийн үзэл баримтлалыг мөн өөрчилсөн. 2001 онд баталсан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын суурь шалгуур үзүүлэлтүүд тэнцвэртэйгээр орсон ч хэрэгжүүлэх арга хэмжээ, төлөвлөгөө, хугацаа, хүрэх үр дүнгийн талаар зохицуулалт сул байв. 2000 онд НҮБ-ын Мянганы хөгжлийн зорилтыг баталсан ба энэ зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд МАХН, Ардчилсан хүчнүүдийн хамтарсан төр засаг 2008 онд Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлого баталсан. Энэ хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрэх үр дүнг 2021 он хүртэл гэж тодорхойлсон. 2012-2016 оны АН-ын төр засаг НҮБ-ын “Тогтвортой хөгжил-2030” батлагдсаны дагуу Монгол Улсын “Тогтвортой хөгжил-2030”-ыг 2016 оны тавдугаар сард батлав. Харин 2019 онд энэ бодлогын баримт бичиг өөрчлөгдөн “Алсын хараа-2050” шинээр гарсан.

Сонгуульд ялсан нам өмнөх төр, засгийн баталсан хөгжлийн үзэл баримтлалыг хүчингүй болгож, шинээр баталдаг “дэг” тогтсон байна. Хэдийгээр улс төрийн үзэл баримтлалын хувьд ялгаатай хэдий ч Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хувьд нэгдмэл байх, залгамж халаа, тогтвортой байх нь чухал.

Урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал, бидний судалгааны үзэл баримтлал болох тогтвортой хөгжлийн үзэл баримтлал Монгол Улсын хувьд тогтворгүй явсаар 25 жилийг үдлээ гэж судлаач дүгнэлээ. Угтаа хамгийн тогтвортой байх ёстой хөгжлийн

¹⁹ Алсын хараа- 2050 ажлын хэсгийн тайлангаас

үзэл баримтлал болох тогтвортой хөгжлийн үзэл баримтлал тогтворгүй байх нь Монгол Улсын хөгжилд саад болж буй нэгэн хүчин зүйл гэж үзэж байна. Үүнд нөлөөлөх субъектив хүчин зүйл бол улс төрийн намуудын төлөвшөөгүй байдал, дотоод ардчилал сул байдаг шалтгаан юм.

4.2. Улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрт Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал тусгагдсан байдал

1990 оны анхны ардчилсан сонгууль:

Энэ хэсэгт тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын нэгдмэл бодлогын баримт бичиг гараагүй үе боловч тухайн үеийн урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалтай холбож судалсан.

1990 оны тавдугаар сард МАХН, шинээр бий болсон намуудын удаа дараагийн зөвшилцөл, хамтын ажиллагааны дүнд 1960 оны Үндсэн хуулийн Нэмэлтийн хууль батлагдаж, төрийн байгууллын тогтолцоогоо шинээр бий болгох их өөрчлөлт эхлүүлсэн. Энэ өөрчлөлтөөр сонгуулийн хуучин тогтолцоог халж шинийг төлөвшүүлэх нөхцөл бүрдсэн.

АИХ-ын сонгуулийг 1990 оны долоодугаар сарын 29-нд зохион байгуулахаар болж, олон намын оролцоотой мажоритар зарчмаар сонгохоор тогтсон нь шинэ сонгуулийн онцлог байв.

Намуудын мөрийн хөтөлбөрийн хөгжлийн суурь үзэл баримтлал нь өмнөх нийгмийн тогтолцоог өөрчлөх, эдийн засгийн хувьд дэлхийн хөгжсөн улс орнуудын жишгээр улсаа хөгжүүлэх нэн тэргүүний зорилтууд тавьсан байдаг. Харин 1960 оны Үндсэн хуульд заасан хүмүүнлэг, ардчилсан социалист нийгэм байгуулах талаар намууд мөрийн хөтөлбөртөө шууд дурдаагүй, ялангуяа социалист гэдэг үг байсангүй.

Сонгуулийн үр дүнд суудал авсан намуудын мөрийн хөтөлбөрт шинжилгээ хийнэ.

Хүснэгт 10. Намуудын мөрийн хөтөлбөр-1990 ба Хөгжлийн үзэл баримтлал

№	Сонгуульд оролцсон нам	Хөгжлийн үзэл баримтлал мөрийн хөтөлбөрт тусгагдсан байдал
1	МАХН	Хүнлэг, энэрэнгүй нийгмийн бодлого, эдийн засгийн бодлого нь дэлхийн аж ахуйн хөгжил, олон улсын хөдөлмөрийн хуваарь, шинжлэх ухаан, техникийн дэвшлийн орчин үеийн ололтод уян хатан зохицох чадвартай, өмчийн олон хэлбэрт тулгуурласан...
2	МоАН	Энэрэнгүй ардчилсан нийгэм байгуулах явдал бөгөөд өмчийн олон хэлбэрийг зөвшөөрөх
3	МСДН	Эдийн засгийн чөлөөт зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх
4	МҮДН	Монгол оронд хүмүүнлэг, ардчилсан, иргэний журамт нийгэм, нийгмийг үндэсний хөгжил дэвшлийн жам ёсонд тулгуурласан...

Гэхдээ энэ талаар тухайн үеийн ардчилсан хувьсгалын манлайлагчдын нэг доктор Ж.Нэргүйн ярилцлагаас сийрүүлбэл: “Улс орны хэмжээнд явагдах улс төрийн том бодлого төр, засаг, намуудын үйл ажиллагааны цөм болж чадахгүй байна. Тулгамдсан асуудлыг голдуу салбарын болон аж үйлдвэр, аж ахуйн газрын төвшинд авч үздэг практик давамгайлсан хэвээр байна” гэж тухайн үед шүүмжилсэн байдаг²⁰.

Судлаачийн дүгнэлт: Хөгжлийн үзэл баримтлал, бодлого талаас авч үзвэл, намуудын хөтөлбөрт тусгагдсан зорилтууд хууль цаазат болон хүмүүнлэг иргэнлэг нийгэм байгуулах, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан эрхийг баталгаажуулах, олон намын тогтолцоог бэхжүүлэх, хувийн өмчийг бий болгох зэргээр тухайн нөхцөл байдалтай уялдаж байв. Ялангуяа энэрэнгүй, иргэнлэг нийгэм байгуулах зорилт бол хөгжлийн философи агуулсан үзэл баримтлалын шинжтэй гэж үзэж болно. Гагцхүү энэ зорилгод хүрэх зорилт, арга хэмжээний талаар намууд мөрийн хөтөлбөртөө хэрхэн уялдуулж тусгасан талаар дэлгэрэнгүй тайлбарласан мэдээлэл алга байна. Энэ хүрээнд сонгогчдод хэрхэн сурталчилсан талаар мэдээлэл хомс байна. Харин өнөөдөр ч гарсаар байгаа сонгуульд нэр дэвшигчид өрсөлдөгчийнхөө нэр төрийг гутаах, эд бараа тараадаг зөрчил энэ сонгуулийн үеэр гарч байжээ²¹.

Мөн намуудын мөрийн хөтөлбөрийг судалж танилцсан хэсэг нь цөөн бөгөөд сонгуулийн тогтолцоо, зохион байгуулалтаас хамаарч хэт олон хүн нэр дэвшиж, улмаар тасаг цехээс эхлээд байгууллага, хамт олон бүр өөрийн депутаттай болох гэсэн өрсөлдөөн гаргахад хүргэсэн гэж Сонгуулийн комиссын даргын илтгэлд дурдагджээ²².

Энэ сонгуулийн хувьд сонгогч анх удаа олон намын төлөөлөл бүхий ардчилсан сонгуульд оролцсон, намуудын мөрийн хөтөлбөр, олон нэр дэвшигчийн (зарим тойрогт 70 хүн өрсөлдсөн байдаг) танилцуулга, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүртээмжгүй байдлаас шалтгаалан намуудын мөрийн хөтөлбөрт заасан хөгжлийн үзэл баримтлалын талаар төсөөлөлгүй байжээ. Нөгөө талаас намууд өөрсдийн намын дүрэм, сонгуульд “оноо” авахын тулд ойрын зайд үр дүнд хүрэх боломжтой зорилтуудыг дэвшүүлж байсан гэж судалгаанд оролцсон иргэд хариулж байв.

1992-1996 оны УИХ-ын сонгууль:

Шинэ Үндсэн хуулиар сонгуулийн эрх зүйн үндсэн зарчмыг тодорхойлон УИХ-ын гишүүнийг сонгуулийн эрх бүхий иргэд сонгодог болов. Ийнхүү Үндсэн хуульд заасны дагуу УБХ-аас 1992 оны дөрөвдүгээр сарын 4-нд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай шинэ хуулийг баталж, зургаадугаар сарын 29-нд сонгууль болжээ. Уг сонгуульд УДШ-эд бүртгэлтэй найман нам, хоёр эвсэл оролцсон.

Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлалын талаар нэгдмэл баримт бичиг гараагүй, Үндсэн хуулийн эрхэм зорилгыг хөгжлийн үзэл баримтлал мөн, эсэх нь эргэлзээтэй үед намууд өөр өөрсдийн мөрийн хөтөлбөрт тодорхойлсон хөгжлийн үзэл баримтлалыг иргэдэд сурталчилж таниулсан байна.

²⁰ Ц.Уртнасан. Монголын нийгмийн бүтцийн судалгаа шинжилгээ бүтээлийн эмхэтгэл. 2017.х.237.

²¹ Г.Хэрлэн. Засгийн газар. 1990-2016 . эмхэтгэл. 2016.

²² Мөн тэнд

Намуудын хувьд хөгжлийн философи нь ерөнхий, мөн МАХН, ардчилсан эвсэл, МСДН-ын хувьд өмнөх 1990 оны сонгуульд баримталж байсан мөрийн хөтөлбөрийн зорилтуудыг хэрхэн биелүүлсэн, залгамж халаа нь ямар байх талаар холбосон зорилт мөн дүгнэлт алга байна.

Сонгуулийн хөтөлбөрөөс харахад урт хугацааны гэхээс илүүтэй тухайн нөхцөл байдалд хамаарах зөвхөн эдийн засгийн бүтцийн болон суурь хэрэглээний онол арга зүй дээр суурилсан хөгжлийн үзэл баримтлалтай байжээ гэж судлаач үзлээ.

Хүснэгт 11. Намуудын мөрийн хөтөлбөр-1992 ба Хөгжлийн үзэл баримтлал


№	Сонгуульд оролцсон нам	Хөгжлийн үзэл баримтлал мөрийн хөтөлбөрт тусгагдсан байдал
1	МАХН	Монголын ард түмний уламжлалт соёл иргэншлийг ардчилсан аргаар хадгалан хөгжүүлэх, Монгол орны нийгмийн дэвшил гуйвшгүй чиг бодлоготойгоор ард түмний дэмжлэгтэйгээр, зөвхөн тэдний тусын тулд хэрэгжих ёстой.
2	МоАН, МНН, МҮДН-ын эвсэл	Хувийн хэвшлийн секторыг эдийн засагт давамгайлах
3	МСДН	

Энэ хэсэгт МСДН-ын мөрийн хөтөлбөрийн эх хувилбар олдсонгүй.

1996-2000 оны УИХ-ын сонгууль:

Монгол Улсын Их Хурлын сонгууль 1996 оны зургадугаар сарын 30-нд сонгуулийн хуулийн дагуу явагдаж, улс төрийн таван нам, МҮАН-МСДН-ын “Ардчилсан холбоо”, МАСН-МАН-ын “Ардчилсан төр” эвслүүд, бие даан нэр дэвшигчид оролцож нам, бие даан нэр дэвшигч бүр өөр өөрсдийн мөрийн хөтөлбөрийг боловсруулан өрсөлдсөн байна.

Ийнхүү 1996 оны тавдугаар сард баталсан Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал болон НҮБ-ын Хөгжлийн зорилт-21 тогтвортой хөгжлийн үзэл баримтлал зэргийг сонгуульд оролцсон намуудын мөрийн хөтөлбөрт хэрхэн тусгасныг харья.



Хүснэгт 12. Намуудын мөрийн хөтөлбөр-1996 ба Хөгжлийн үзэл баримтлал

№	Сонгуульд оролцсон нам	1996 оны Хөгжлийн үзэл баримтлалыг үндэслэсэн байдал	Өөр бодлогын баримт бичиг болон үзэл баримтлал	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хангасан зорилт байгаа эсэх
1	МАХН	Үгүй	Монгол Улсын үндэсний хөгжлийн ойрын ирээдүйн зарим асуудлаар МАХН-ын баримтлал”, “Монгол Улс төрийн шинэчлэлийг идэвхжүүлэх МАХН-ын байр суурь”-т үндэслэн	Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, байгаль орчинд хор хөнөөл багатай хаягдалгүй технологи бүхий үйлдвэрлэл хөгжүүлэхийг
2	МУАН-МСДН-ын “Ардчилсан холбоо”	Үгүй	Байгаль орчны талаар унаган байгалиа хамгаалах, нөөц баялгийг ирээдүйн залгамж үеийн эрх ашгийн үүднээс зохистой ашиглах, экологийн баримжаат төрийн бодлого хэрэгжүүлнэ	
3	МУНН	Үгүй	Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг бодлого ялангуяа уламжлалт хөдөө аж ахуйд суурилсан эдийн засгийн бодлого барина гэж тусгасан байна	

Судлаачийн дүгнэлт: МАХН өмнөх төр засгийн буюу 1992-1996 онд хэрэгжүүлсэн мөрийн хөтөлбөрийн зорилтуудыг хэрхэн биелүүлсэн, залгамж халаа нь ямар байх талаар холбосон агуулгыг мөрийн хөтөлбөртөө тусгажээ. Харин өмнөх буюу өөрийн намын байгуулсан төр засгийн шийдвэр болох Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлалыг баримтлан мөрийн хөтөлбөрөө боловсруулаагүй байна. Жишээ нь, Монгол Улс ойрын ирээдүйд оюуны болон технологийн шинэ суурьт тулгуурласан, *экспортын баримжаатай*, харьцангуй биеэ даасан эдийн засагтай үйлдвэржсэн орон буюу 2001-2010-аад оны эхэн үе гэхэд хүрнэ гэж Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд заасан бол МАХН-ын сонгуулийн намын хөтөлбөрт *нийгмийн баримжаатай* зах зээлийн эдийн засгийг төлөвшүүлэх гэж тодорхойлжээ.

Ихэнх намуудын мөрийн хөтөлбөрт Монгол Улсын Хөгжлийн болон НҮБ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын зарчим, зорилтоос заримыг нь дурдсан боловч Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлалд заасан 15-25 жилийн хугацааг дурдаагүй, төлөвлөлт, авах арга хэмжээ, хүрэх үр дүнгийн талаар дурдаагүй, уялдаа холбоо хангалтгүй байна гэж дүгнэлээ. Ялангуяа тогтвортой хөгжлийн шалгуур болох байгаль орчин, эдийн засгийн өсөлт, нийгмийн тэгш байдлыг тэнцвэртэй хангах зарчмыг тусгасангүй.

2000-2004 оны УИХ-ын сонгууль:

Сонгуулийн тогтолцоо өмнөхтэйгөө ижил байсан бөгөөд 13 нам, гурван эвсэл өрсөлдсөн.

1998 онд баталсан Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг намууд сонгуулийн мөрийн хөтөлбөртөө уялдуулан, зорилт, хүрэх үр дүнг тодорхойлж чадсан, эсэхийг харъя.

Хүснэгт 13. Намуудын мөрийн хөтөлбөр-2000 ба Хөгжлийн үзэл баримтлал

№	Сонгуульд оролцсон нам	1998 оны Тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрийг үндэслэсэн, эсэх	Өөр бодлогын баримт бичиг болон үзэл баримтлал	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хангасан зорилт байгаа, эсэх
1	МАХН	Үгүй	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлуулан хэрэгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, амьдралын түвшний зөрүүг багасгахад оршиж байна.	Эдийн засгийн тогтвортой өндөр өсөлт гээд уул уурхайн салбарыг түлхүү хөгжүүлэх тухай заан, байгаль орчныг хамгаалах гэхээсээ ухаалаг ашиглах үзэл баримтлалыг голложээ.
2	МҮАН-МШАН			
3	Иргэний Зориг-Ногоон Нам” эвсэл	Үгүй	Нийгэм-экологийн баримжаатай зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх	Ерөнхий тэнцвэрийг хангах гэж зорилтоо тодорхойлсон
4	Эх Орон-МАШСН	Үгүй	ДНБ-ыг өсгөх, үйлдвэржилтийн бодлогыг дэмжсэн байна	Үгүй

МҮАН-МШАН-ын хөтөлбөрийн эх хувилбар олсонгүй.

Судлаачийн дүгнэлт: Намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийхэд МАХН нь Эх Орон-МАШСН-ын мөрийн хөтөлбөрт буюу өмнөх Засгийн газрын явуулсан эдийн засгийн бодлогод шүүмжлэлтэй хандсан байна. Жишээлбэл, эдийн засгийн өсөлтийн хурдац удааширч 1995 оны түвшинтэй харьцуулахад бараг хоёр дахин буурлаа. Манай улсын эдийн засаг ийм хурдцаар өсвөл нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээр 2010 оны орчимд л 1989 оны түвшинд хүрэх буюу бүхэл бүтэн үеийн туршид монголчууд ядуу дорой байх дүр зураг харагдаж байна гэжээ. Хөгжлийн стратеги, цэгцтэй бодлого, зохицуулалтгүйн улмаас Засгийн газраас хэрэгжүүлсэн өөрчлөлт шинэчлэлийн арга хэмжээ үр дүнд хүрсэнгүй. Нийгмийн салбарын үзүүлэлтүүд өмнө хүрсэн түвшнээс буурсаар байна. Ажилгүйчүүдийн тоо

230-аад мянгад хүрч, ядуурал өдрөөс өдөрт нэмэгдсээр манай оронд өнөөдөр 870 мянган хүн ядуу амьдарч байна гэжээ.

Харин энэ бүх сөрөг бууралт өмнөх дөрвөн жилийнх үү, эсвэл 1990 оноос хойших уу гэдэгт үндэслэлтэй судалгааг сонгогч харах ёстой. Ингэж тооцоо судалгаанд үндэслээгүй дүгнэлт эргээд өмнөх засгийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх, залгамж чанар алдагдахад хүргэдэг.

Энэ цаг үеэс намуудын мөрийн хөтөлбөрт ойрын зайд хэрэгжих эдийн засгийн өсөлт болон нийгмийн тэгш байдлыг хангах зорилгоор гэх нийгмийн халамжийн чиглэлийн бодлого буюу амлалтууд орж ирсэн. Үүний шалтгаан нь 1990 оноос хойших эдийн засгийн хямралын улмаас ажилгүйдэл, ядуурлын тоо ихэссэнтэй холбоотой юм. Жишээ нь, 1990 онд Хүний хөгжлийн индексээр 170 орноос 61 дүгээр байранд орж байсан бол 1999 онд 119 дүгээр байр луу ухарсан байна²³. Тодруулбал, МАХН-ын мөрийн хөтөлбөрт эдийн засгийг зургаан хувиар өсгөнө гээд энэ зорилтод хүрэхийн тулд мал аж ахуйн гаралтай түүхий эд, ялангуяа мах, ноолуур, хонь, тэмээний ноос, арьс ширний боловсруулалтын түвшинг ахиулах, экспортын орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэд хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ гэжээ. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны зардлыг улс бүрэн хариуцна. Малчны болон хоёроос дээш хүүхэд нь зэрэг суралцаж байгаа айлын нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төр даана. Цаашид сургалтыг төлбөргүй болгох чиглэл баримтална гэж холбон зорилтоо дэвшүүлжээ. Энэ нийгмийн бодлогыг хангах эдийн засгийн боломжийг уул уурхайг дэмжих бодлоготой уясан байна.

Харин энэ бүх зорилтыг хэрэгжүүлэхэд байгаль орчин, бэлчээрийн даац, малчин айлын хүүхдийн боловсрол, малчдын эрүүл мэндийг харгалзсан цогц бодлого хэрэгтэй байсан юм.

Бүх намын мөрийн хөтөлбөрт хөгжлийн урт, дунд, ойрын хугацааны зорилт, төлөвлөгөө, хүрэх үр дүн, хугацааг тодорхой зааж өгөөгүй байна.



²³ Монгол улсын хөгжлийн судалгаа. ҮХХ.2006(1) х. 19

2004-2008 оны УИХ-ын сонгууль:

Энэ сонгуульд улс төрийн долоон нам дангаараа, гурван нам эвсэл болж оролцсон. 2001 онд баталсан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг сонгуульд оролцож буй намууд мөрийн хөтөлбөртөө хэрхэн тусгасныг авч үзье. Ингэхдээ тогтвортой хөгжлийн гурван шалгуур үзүүлэлтийг хангасан, эсэхээр шалгая.

Хүснэгт 14. Намуудын мөрийн хөтөлбөр-2004 ба Хөгжлийн үзэл баримтлал

№	Сонгуульд оролцсон нам	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг үндэслэсэн, эсэх	Өөр бодлогын баримт бичиг болон үзэл баримтлал	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хангасан зорилт байгаа, эсэх
1	МАХН	Улсын Их Хурлын 2000 оны сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрийнхөө хэрэгжилтийн гол гол үр дүнг бататган үргэлжлүүлж,...		Байгаль орчны бодлого, арга хэмжээг бүсчилсэн хөгжлийн зорилттой уялдуулж улс орны тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлнэ. Гэхдээ үндсэн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын шалгуур үзүүлэлтийн тэнцвэрийг хангасангүй.
2	Эх орон-Ардчилал эвсэл	Үгүй	Бизнесийн салбарын чөлөөт байдлыг дээшлүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангах	Үгүй
3	БНН	Үгүй	Эдийн засгийн бодит өсөлтийг нэмэгдүүлэх, төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засгийг дэмжих, экологийн үндсэн тэнцвэр хадгалсан оюуны багтаамж бүхий технологийн шинэ орчинд тулгуурласан эрчимтэй хөгжсөн үйлдвэржсэн орон болох	Экологийн эдийн засаг, экологийн нийгэм гэсэн бодлого явуулна

Судлаачийн дүгнэлт: Энэ жилийн сонгуульд оролцсон намуудаас өмнө нь батлагдсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд үндэслэж мөрийн хөтөлбөрөө боловсруулсан нь МАХН байна. Бусад намын хөтөлбөрийг харахад энэ бодлогын

баримт бичгийг үндэслэсэн гэх үг алга байна. Гэхдээ өмнөх сонгуулийн мөрийн хөтөлбөртэй харьцуулахад НҮБ-ын тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн зорилтуудыг тусгасан, уг зорилтод хүрэх үр дүн арга хэмжээний талаар багахан ч болов харгалздаг болсон байна. Харин энэ сонгуулиас эхлэн МАХН, Ардчилсан нам хоёрын амлалтын уралдаан эхэлсэн гэж үзэхээр байна. МАХН залуу гэр бүлүүдэд 500 000, хүүхэд төрөхөд 100 000, АН итгэлийн мөнгө буюу хүүхэд тус бүрд 10 000 өгөх тухай амлалт өгчээ. Ийнхүү намууд мөнгө амлах болсон үндсэн шалтгаан юу вэ?

Алт, зэсийн үнэ 2001 оноос өсөж, үүнээс шалтгаалан эдийн засгийн өсөлт тогтвортой дээшлэх болсон. Томоохон алтны уурхай “Бороо гоулд” компанийн үндсэн орд ашиглалтад орсон юм. Энэ нь эдийн засгийн өсөлтийг авчирсан ч нөгөө талдаа байгаль орчныг хамгаалах, цөлжилт, нөхөн сэргээлтийн асуудлыг орхигдуулсан гэдгийг өнөө цаг үед судлаачид, мэргэжилтнүүд бичсээр байна.

2008-2012 оны УИХ-ын сонгууль:

Томгосон мажоритар буюу нэг тойрог-олон мандат хэлбэрээр явуулсан сонгууль нь 1992 оны сонгуультай ижил. Энэ сонгуульд нийт 12 нам, нэг эвсэл, 45 хүн бие даан нэр дэвшжээ.

2008 оны нэгдүгээр сард УИХ-аас баталсан Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (ҮХЦБ)-ыг мөрийн хөтөлбөр боловсруулахдаа харгалзсан, эсэх

Хүснэгт 15. Намуудын мөрийн хөтөлбөр-2008 ба Хөгжлийн үзэл баримтлал

№	Сонгуульд оролцсон нам	Үндэсний хөгжлийн цогц бодлогод үндэслэсэн, эсэх	Өөр бодлогын баримт бичиг болон үзэл баримтлал	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хангасан зорилт байгаа, эсэх
1	МАХН	Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлоготой нягт уялдан хэрэгжих мөрийн хөтөлбөрөө 12 багц зорилтоор нэгтгэн боловсруулжээ.		Хангасан
2	АН	Үгүй	10 жилд улс орноо хөгжүүлэх 10 зөв бодлогыг	Эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэж байв.
3	Иргэний эвсэл	Үгүй	Тодорхой биш	Хангасан
4	ИЗН	Үгүй	Тодорхой биш	Хангасан

Судлаачийн дүгнэлт: Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг харгалзсан гэдгээ хоёр ч нам мөрийн хөтөлбөртөө дурджээ. Харин уул уурхай ашиглалт, баялгийн олборлолтоос улбаалж нийгэмд иргэний хөдөлгөөн,

байгаль хамгаалах төрийн бус байгууллага идэвхжиж, жагсаал цуглаан хийх нь олширсон тул бүх намын мөрийн хөтөлбөрт байгаль хамгаалах ба уул уул уурхайн асуудал хөндөгдсөн байна. 2008 оны УИХ-ын сонгуулиар МАХН Эх орны хишиг 1 500 000, АН-ын дэвшүүлсэн Эрдэнийн хувь 1 000 000 төгрөг амласан байдаг.

2012-2016 оны УИХ-ын сонгууль:

Улсын Их Хурлын энэ удаагийн сонгуулийг хууль, эрх зүйн шинэ орчинд сонгуулийн хосолсон тогтолцоогоор анх удаа зохион байгууллаа. Монгол Улсын Их Хурлын сонгуульд улс төрийн 11 нам, хоёр эвсэл оролцсон.

Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого хэрэгжиж байсан тул намуудын хөтөлбөрт тусгагдсан байдлыг харья.

Хүснэгт 16. Намуудын мөрийн хөтөлбөр-2012 ба Хөгжлийн үзэл баримтлал

№	Сонгуульд оролцсон нам	Үндэсний хөгжлийн цогц бодлогод үндэслэсэн, эсэх	Өөр бодлогын баримт бичиг болон үзэл баримтлал	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хангасан зорилт байгаа, эсэх
1	МАН	Үгүй	Тодорхойгүй	Хангасан зорилтууд байна.
2	АН	Үгүй	Тодорхойгүй	Зарим зорилт байна.
3	ИЗНН	Үгүй	Амьдрал хэмээх үзэл баримтлал	Энэ дэвшүүлсэн зорилго нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын гурван шалгуур үзүүлэлтийн тэнцвэрийг хангаж чадсан гэж үзлээ.
4	Шударга ёс эвсэл	Үгүй	Монголоо аврах таван хувьсгал” хэмээх зорилтын...	Зарим зорилт тусгагдсан.

Судлаачийн дүгнэлт: Энэ сонгуулийн онцлог бол сонгуулийн мөрийн хөтөлбөрт намууд мөнгөн амлалт өгч, сонгогчдын саналыг худалдаж авахгүй байх талаар зохицуулалт хуульд оруулсан тул мөнгөн амлах нь багассан.

2016-2020 оны УИХ-ын сонгууль:

Сонгуульд 12 нам, гурван эвсэл оролцсон. УИХ олон мандат бүхий сонгуулийн тойргийн тогтолцоог нэг мандат бүхий тойргийн систем болгон өөрчилсөн.

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ын талаар намууд мөрийн хөтөлбөртөө хэрхэн тусгасныг харья.

Хүснэгт 17. Намуудын мөрийн хөтөлбөр-2016 ба Хөгжлийн үзэл баримтлал

№	Сонгуульд оролцсон нам	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	Өөр бодлогын баримт бичиг болон үзэл баримтлал	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хангасан зорилт байгаа, эсэх
1	МАХН	Үгүй	Ерөнхий	Хангасан
2	АН	Үндэслэсэн		Хангасан
3	МАХН	Үгүй	Сонгуулийн хувьсгалаас хөгжлийн хувьсгал руу	Тодорхойгүй

Судлаачийн дүгнэлт: Нам эвсэл, бие даан нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Төсвийн тогтвортой байдлын тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлсэн байдал болон хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг төрийн аудитын байгууллагаар хянуулсан байхыг Сонгуулийн тухай хуульд заасан.

4.3. Сонгуулийн дараа төр засгийн шийдвэрт Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал тусгагдсан, эсэх

1990-1992 он:

Санал хураалтаар 430 тойргоос депутат сонгогдсон. Энэ сонгуулиар МАХН 343, МоАН 23, МҮАН долоо, МСДН дөрөв, Монголын чөлөөт хөдөлмөрийн нам нэг суудал авч, 51 хүн нам бусаас нэр дэвшин сонгогдов.

Сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Засгийн газар 1990 оны арванхоёрдугаар сарын 27-нд мөрийн хөтөлбөрөө батлуулсан. Хэдийгээр сонгуульд МАХН олонх болсон учир Засгийн газраа дангаараа байгуулах боловч сөрөг хүчнээс кабинетдаа оруулснаараа онцлог юм. Мөн энэ Засгийн газрын бүтцэд Үндэсний хөгжлийн яамыг багтаасан байна.

Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн үндсэн агуулга нь *улс орны одоогийн нөхцөл байдалд бодитой үнэлэлт, дүгнэлт өгч, монгол орны сэргэн мандлын үзэл санааг удирдлага болгон хөгжлийнхөө чиг баримжааг оновчтой тогтоож...* гэж

тодорхойлжээ. Харин **БНМАУ-ын Үндсэн хуульд байх ардчилсан социалист хөгжлийн зорилготой уялдаа холбоо бүхий үг хөтөлбөрт байсангүй.**

1990 оны гуравдугаар сард Үндсэн хуульд оруулсан хөгжлийн үзэл баримтлалын өөрчлөлт есдүгээр сард Засгийн газраа байгуулах үед авч хэрэглэх боломжгүй байсан гэдгийг анхаарахгүй өнгөрч болохгүй. Энэ цаг үед сар, өдөр, цагаар нийгмийн үзэгдэл, орчин өөрчлөгдөж байсныг харгалзах нь зүйтэй болов уу.

Засгийн газрын хөтөлбөрийн онцлогийг Ерөнхий сайд Д.Бямбасүрэн: “Манай мөрийн хөтөлбөрийн нийгмийн бодлогын бүлэг нь МАХН-ын байр суурийг, эдийн засгийн тогтолцоог өөрчлөх чиглэлд МҮДН, ардчиллын хууль ёсны чиглэлд МоАН-ын үзлийг илүүтэй тусгаж байсан гэжээ²⁴.

Монгол орны сэргэн мандлын үзэл санааг тодорхойлохдоо эх орон, эрх чөлөө, эрдэм оюун бүтээлч чадвар, эгэл жирийн хүний аз жаргалтай амьдралын хүсэл мөрөөдлийн биелэл нийгмийн хөгжлийн гол шалгуур байх болно гэж үзэж байжээ. Энэ хүрээнд нийгмийн бодлогын 53, шинжлэх ухаан, технологийн 40, эдийн засгийг зах зээлийн эдийн засагт шилжүүлэх 53, байгаль орчны бодлого 15 гэх мэтээр ажил төлөвлөсөн байна²⁵. Харин эдгээр төлөвлөгөөт ажлын хугацаа, хүрэх үр дүнгийн талаар тооцоолол бүрхэг байна.

Энэ цаг үед судалгааны гол үзэл баримтлал болох тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг тодорхойлж өгсөн бодлогын баримт бичиг гараагүй тул шалгуур үзүүлэлтийн дагуу шалгах боломжгүй байлаа.

Сонгуулийн жилүүдэд хөгжлийн үзэл баримтлал, бодлоготой хамаарах АИХ, УБХ, Засгийн газрын шийдвэр, нийгэмд өрнөсөн олны анхаарлыг татсан бусад үйл явдалтай танилцъя.

1. 20 дугаар тогтоол:

1991 оны нэгдүгээр сард “Эдийн засгийг зах зээлийн зохицуулалтад шилжүүлэх зарим арга хэмжээний тухай 20 дугаар тогтоол гаргажээ. Гэхдээ зах зээлийн харилцаанд шилжих явцад ийнхүү үнийг чөлөөлснөөр Монгол Улс гипер инфляцтай нүүр тулсан²⁶. Сонгуулийн эрх бүхий иргэдийн 98 хувь нь оролцсон 1990 оны сонгуульд намуудын мөрийн хөтөлбөрүүдэд дурдагдсан зах зээлийн эдийн засагт шилжих тухай ерөнхий зорилт байсан ба харин авах арга хэмжээний талаар мэдээлэл байсангүй. Сонгогчдын дийлэнхэд нь энэ талаар төсөөлөл байгаагүй нь тухайн үеийн өдөр тутмын сонин, хэвлэл, радио, телевизэд хандсан ярилцлага, шүүмжлэлээс харагдаж байна.

2. Өмч хувьчлал:

1991 оны тавдугаар сард УБХ-аас БНМАУ-ын өмч хувьчлах хуулийг баталсан. Тухайн үеийн төрийн өмчид байсан нийт хөрөнгийн 44 хувийг хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьчлах асуудал эхэлсэн юм. Мөн энэ бодлогын арга хэмжээ нь сонгуулийн намуудын мөрийн хөтөлбөрт маш ерөнхий, хэрэгжүүлэх арга зам нь тодорхойгүй байсан. Сонгогчид энэ талаар мэдээлэл, мэдлэг байсангүй. Мөн энэ судалгааг хийх явцад ч тухайн үед сонгууль өгч байсан иргэд өмч хувьчлах талаар ямар ч ойлголтгүй санал өгсөн. Дараа нь энэ үйл явцад сэтгэл дундуур байснаа илэрхийлсэн байна (4.4 хэсгээс харна уу).

²⁴ Д.Бямбасүрэн. Үүрийн жавар. 1996. х.156

²⁵ Монгол төрийн эдийн засгийн бодлого: сорилт, сургамж, асуудал.1911-2018. х.285

²⁶ Д.Ган-Очир. Монголын хөгжлийн зам. Сургамж, сорилт, боломж. 2020. х.30

3. Зөвлөлтийн цэрэг, мэргэжилтэн Монголоос гарсан үйл явдал: Ардчилсан гэгдэх намуудын хөтөлбөрт дурдагдсан. Эрчим хүчний салбараас 600 мэргэжилтэн буцахад эрчим хүчний салбарт доголдол гарчээ.

4. 1991 оны дөрөвдүгээр сард БНМАУ-ын Банкны хууль батлагдсан. Энэ хуулиар хоёр шатлал бүхий банкны тогтолцоо үүссэн. Арилжааны банк болох Ард, ХОТШ, худалдаа, хөгжлийн зэрэг банкууд бий болсон²⁷. Банкнууд бага хүүтэй зээлийг хяналтгүйгээр их хэмжээгээр олгосноос мөнгөний нийлүүлэлтэд хямрал бий болсон. 1993-1996 оны хугацаанд зургаан банк дампуурахад нөлөөлсөн гэж судлаачид үзжээ.

5. Картын барааны үе: 1991 оны аравдугаар сараас хүнсний хомстол үүсэж картын барааны системд шилжсэн. Намуудын мөрийн хөтөлбөрт барааны хомстол зэрэг үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх тооцоо судалгаа байсангүй.

6. Шинэ Үндсэн хууль батлах үйл явц: Бүх намуудын сонгуулийн хөтөлбөрт дурдагдсан.

7. Алт дилерийн хэрэг: 1991 оны аравдугаар сарын байдлаар Монголбанкны гадаад валютын нөөцөд нийт 92.6 сая ам.долларын алдагдал гарсан байна.

8. Нэгдэл тарж, малыг малчдад хувьчлав. 321 хөдөө аж ахуйн нэгдэл задарч, 23 сая мал хувийн өмчид шилжив.

Тоон мэдээлэл: 1990-1992 онд ДНБ 20 орчим хувиар, импорт 2.6 дахин буурч, ажилгүйдлийн түвшин 8.5 хувь хүрч, хүн амын 30 гаруй хувь нь нэн ядуу аж төрөх болж, 1992 онд Монгол Улс дэлхийн өндөр инфляцтай 10 орны зургаадугаарт бичигдэж байжээ²⁸.

1990-1992 онд ардчилсан нийгмийн шилжилтийг хийх төрийн байгуулалт, хүний эрх, эрх чөлөөний суурь эрх зүйн зохицуулалтыг батлах явц эрчимтэй явагдсан ч эдийн засгийн хувьд хүндхэн он жилүүд байсан. Зарим судлаач макро түвшний биш микро эдийн засгийн шинэчлэл буюу Азийн шилжилтийн аргыг хэрэгжүүлсэн бол цаашдын хөгжилд үр нөлөөтэй байсан гэж үзжээ. Тодруулбал, шилжилтийн онолын үзэл баримтлал буруу, хөгжлийн бодлого нь судалгаа шинжилгээнд сайтар үндэслээгүй, үндэсний эдийн засгийн онцлог, ард түмний язгуур эрх ашгийг тэргүүн зэрэгт тавиагүй, өөрийн орны онцлогт тохирсон дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулж, хэрэгжүүлж чадаагүйтэй холбоотой юм. Монгол Улсад “цочир эмчилгээний” эдийн засгийн загварын дагуу үндэсний боловсруулах үйлдвэр, аж ахуйн газруудын хувьчлалыг ямар ч бодлогогүйгээр өргөн хүрээтэй явуулсан бөгөөд хувьчлан авсан эзэд нь тэдгээрийг ажиллуулж чадаагүйн улмаас олон зуун үйлдвэр, үйлчилгээний болон аж ахуйн газрууд хаалгаа барьж, олон мянган ажилчныг “гудамжинд гаргаж”, ажилгүйчүүдийн тоог эрс нэмэгдүүлэн, өнөөгийн ажилгүйдэл, ядуурлын суурийг тавьсан²⁹ гэсэн бол нөгөө хэсэг нь ийнхүү цочир өөрчлөлт хийх нь зогсонги байсан эдийн засгийг хурдан хөгжүүлэхэд түлхэц болсон гэж үздэг. Судлаач энэ талын нарийвчилсан мэддэг эзэмшээгүй тул зөв бурууг шүүхгүй, харин тухайн үед урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалд суурилсан төрийн бодлого байсан, эсэх талаар мэдээлэл өгөхийг зорьсон болно.

²⁷ Б.Батхшиг. Монголын эдийн засгийн хөгжлийн асуудал. 2018. х.51

²⁸ Монгол улсын хөгжлийн судалгаа. Үндэсний хөгжлийн хүрээлэн. 2006.х.17

²⁹ Монгол улсын хөгжлийн бодлогын тогтвортой байдал, залгамж чанар, уялдаанд хийсэн тайлан. 2018. ҮХГ.

1992-1996 он:

Сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Засгийн газар 1992 оны есдүгээр сарын 28 -нд мөрийн хөтөлбөрөө батлуулсан. Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг МАХН-ын мөрийн хөтөлбөрт үндэслэн боловсруулжээ. Мөн адил Монгол Улсын Хөгжлийн нэгдмэл үзэл баримтлалын баримт бичиг гараагүй ч 1992 оны зургадгаар сард НҮБ-ын дээд хэмжээний Рио-гийн хуралд манай улс оролцож, Хөгжлийн хөтөлбөр-21-ийг хүлээн авсан билээ.

Судлаачийн зүгээс Засгийн газрын мөрийн хөтөлбөр нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр-21-г заасан хөгжлийн үзэл баримтлалыг хэрхэн харгалзсан, эсэх талаар харьцуулж үзлээ. Ингэхдээ байгаль орчин, нийгэм, эдийн засаг гэсэн гурван үндсэн тулгуур зарчмыг тэнцвэртэй тусгасан, эсэх талаар зарим зорилт дээр жишээлэн авч үзэв.

Засгийн газрын мөрийн хөтөлбөрт байгаль орчныг зөвхөн салбарын бодлогын хүрээнд авч үзжээ. Эдийн засгийн бодлогын хувьд сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан ардчилсан, зах зээлийн харилцаанд цэгцтэй шилжүүлэх гэж үндсэн агуулгаа тодорхойлжээ. Цэгцтэй гэдгээ харин тайлбарласан үндэслэл тодорхойгүй байна. Өмнөх засгийн бодлогын үргэлжлэл залгамж холбоо байгаа, эсэхэд дүн шинжилгээ хийхэд эдийн засгийн “муужруулах” буюу шок эмчилгээнээс эдийн засгийг тогтворжуулах арга хэмжээ авна гэсэн байна. Учир нь макро эдийн засгийн тогтворгүй байдлаас банкны салбар хямарч, мөнгөний нийлүүлэлт, хяналт үндсэндээ зохицуулалтгүй болсон байна. Төрийн зохицуулалтгүй зээл олгосноос хойш үндэсний мөнгөн тэмдэгт суларчээ³⁰ гээд эдийн засгийн салбарт либерал шинэчлэл хийхээс түдгэлзсэн гэж дүгнэж болно.

Засгийн газрын хөтөлбөр мөн л бүхэлдээ богино зайн эдийн засгийн хэрэглээний онол дээр суурилсан байна гэж үзлээ. Жишээлбэл, энэ мөрийн хөтөлбөрт “Газрын тос”, “Алт” хөтөлбөрийг хэрэгжүүлж, эдийн засагт нэмэр болно гэсэн агуулгаар заасан байна. Уг хөтөлбөр хөрөнгө оруулалтыг татаж, улс орны эдийн засгийн хүнд үеийг даван туулахад гол нөлөө үзүүлсэн гэж үздэг. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд алтны жилийн олборлолт 0.7 тонноос 11 тоннд хүрч, шороон ордуудыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад түшиглэн ашиглалтад оруулан, ихээхэн хэмжээний татварын орлогыг улсын төсөвт төвлөрүүлжээ. Гэтэл нөгөө талаас ялангуяа тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын зарчмын дагуу “Алт-1” байгаль орчинд хамгийн халтай төсөл болсон гэж судлаач үзэж байна. Олборлолтын эхэн үедээ нөхөн сэргээлт болон байгаль хамгааллын арга хэмжээ авч хэрэгжүүлдэггүй байсан нь “Алт-1” хөтөлбөрийн гол алдаа байв. Ихэнх шороон ордод ашиглалтын хаягдал үүссэн нь гар аргаар алт олборлогчид буюу “нинжа” нарыг бий болгосон юм. Шарын гол, Заамар, Баянхонгорын алтны ордууд дээр ийм нөхцөл байдал үүссэн. “Алт” хөтөлбөр эхэлж байх үе буюу 1992-1996 онд компаниудын техникийн нөхцөл байдал муу, нөхөн сэргээлтийн талаарх ойлголт бараг байхгүй байсан нь сөрөг үр дагавар дагуулсан. “Алт” хөтөлбөр хэрэгжүүлснээр 5700 га газар эвдрэлд орж Ерөө, Заамар зэрэг газарт

³⁰ Ч.Ган-Өлзий. Тогтвортой хөгжил: оюуны ертөнцийн философи. 2018. х.30

усны бохирдол ихэссэн, ялангуяа Заамар дахь алтны үйлдвэрүүдэд хүрээлэн байгаа орчныг хамгаалах менежментийн систем байхгүйгээс эко систем нь ноцтой гэмтсэн гээд таагүй баримт олон бий.

Гэтэл НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр-21-д байгаль орчинд ээлтэй эдийн засгийн тэнцвэртэй бодлогыг хэрэгжүүлэхийг дэлхий улс орнуудын удирдагч нарт уриалсан байдаг. Нийгмийн бодлогын хүрээнд хүн амыг тогтвортой өсгөх гэж томьёолсон нь эдийн засаг, байгаль орчны бодлоготой хэрхэн тэнцвэртэй байх талаар тодорхой үндэслэл харагдахгүй байна.

Сонгуулийн жилүүдэд хөгжлийн үзэл баримтлал, бодлоготой хамаарах УИХ, Засгийн газрын шийдвэр, нийгэмд өрнөсөн олны анхаарлыг татсан бусад үйл явдалтай танилцъя.

1. 1992 оны аравдугаар сард ардчилсан хүчний гэгдэх таван нам буцаж нэгдэж МҮАН байгуулав. Энэ намын эдийн засгийн хөгжлийн үндсэн үзэл баримтлал нь Иргэн баян бол улс баян гэсэн агуулгаар тодорхойлогдов. Харин хүн байгалийн амин шүтэлцээг эрхэмлэн дээдэлж, нийгмийн үйлдвэрлэлийн сав шимийн ертөнцийн оршихуй жамд зохицолдуулахыг чухалчилна гэж заасан нь НҮБ-аас гаргасан 21 дүгээр зууны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг харгалзсан болов уу гэж үзлээ.

2. 1993 онд бүх нийтээрээ сонгох анхны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль явагдав. Энэ сонгуульд УИХ-д олонх болсон намаас нэрээ дэвшүүлсэн хүн ялагдах хүлээв.

3. УИХ-аас 1994 онд Ашигт малтмалын тухай хуулийг баталж, уул уурхайг дэмжсэн төрийн бодлогын эх үүсвэрийг тавив. Харин энэ хуульд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг баримтлаагүй зөвхөн эдийн засгийн агуулгаар хуулийн зорилтыг тодорхойлсон байдаг. Хууль батлах гол хөрс нь тухайн улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал байна. Хэдийгээр энэ сонгуулийн жилүүдэд нэгдмэл байдлаар хөгжлийн бодлогын баримт бичиг гараагүй ч Үндсэн хуульд тунхагласан хүмүүнлэг нийгмийн зорилтыг харгалзах нь зүйтэй юм. Гэхдээ энэ цаг үед энэ талаар хөөцөлддөг байгууллага, хүмүүс цөөн байжээ гэж судлаач дүгнэж байна.

4. 1995 оны багш нарын ажил хаялт. Багш нарын цалин нэмэгдүүлэх зорилгоор ажил хаялт болсон. Энэ нь өмнөх жилүүдийн боловсролын салбарын шинэчлэл, бодлогын асуудлыг онцгойлон авч үзээгүйгээс үүдэлтэй юм. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын дагуу бол боловсролын салбар нь тэргүүлэх чиглэлийнх байдаг.

5. Айбекс-Моламын хэрэг. 1995 онд Монгол Улсын газар нутгийг Айбекс гэдэг группэд 90 жилийн хугацаатай концессоор олгох, мөн Молоам гэгч группэд Монгол Улсын агаарын орон зай, гадаад худалдааны эрхийг 60 жилийн хугацаатай олгох тухай гэрээнүүдийн талаарх дуулиан гарав.

6. Банкны үргэлжилсэн хямрал

7. УИХ-аас татварын багц, байгаль орчны багц хуулиуд батлагдсан.

Тоон мэдээлэл: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих явцад эдийн засгийн нааштай өөрчлөлт гарсан. Үйлдвэрлэлийн уналтыг зогсоож, картын системийг халж, хүнсний бүтээгдэхүүний хомсдолыг арилгасан. 1994 онд ДНБ 2.3 хувь, 1995 онд

6.3 хувь өсөж, 1992 онд 32.5 хувьтай байсан инфляцын түвшин 1995 онд 53.1 хувь болсон байжээ³¹.

1996-2000 он:

Сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Засгийн газар 1996 оны аравдугаар сарын 17-нд мөрийн хөтөлбөрөө батлуулсан. Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг эвслийн мөрийн хөтөлбөр болох Сонгогчидтой байгуулах гэрээнд үндэслэн боловсруулсан бөгөөд 1996-1998, 1998-2000 гэж хоёр үе шатад зорилтуудаа хуваарилсан байна. 1996 оны Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлалын талаар огт дурдсангүй. Харин ч эвслийн Засгийн мөрийн хөтөлбөрт зах зээлийн эдийн засагт шилжих шилжилт удааширч, өмнөх засгийн газрын тогтворжуулалтын бодлого нь эдийн засгийн өсөлтөд урт хугацаанд гацаа болсон тул үнэ чөлөөлөх бодлогыг хэрэгжүүлнэ гэжээ. Өмнөх засгийн төсөвтэй уялдаагүй Төрийн албаны тухай, Нийгмийн халамжийн тухай хуулиуд гарсан байна гээд 1996-1998 онд төрийн албан хаагчдыг цомхотгох, тэтгэвэр, халамж авах хүмүүсийг багасгах талаар арга хэмжээ авна гэжээ.

Харин энэ үед сөрөг хүчний зүгээс Хөгжлийн үзэл баримтлалд тусгагдсан байсан нийгмийн баримжаатай эдийн засгийн бодлого барьсангүй гэж шүүмжилж байв. Мөн 1998-2000 онд нийгэм экологийн болон экспортын баримжаатай эдийн засгийн оновчтой бүтэц бий болгоно гэж Засгийн газрын мөрийн хөтөлбөрт төлөвлөсөн нь Хөгжлийн үзэл баримтлалд буй байгаль орчиндоо зохицсон, оюуны болон технологийн шинэ суурьт тулгуурласан, экспортын чиглэл бүхий эдийн засагтай болох зорилтыг хангасан байна. Гэхдээ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт хөгжлийн үзэл баримтлалыг ерөнхий агуулгаар нь дурдсан болохоос бодлогын шинжтэй арга хэмжээ, хүрэх үр дүнгийн талаар тодорхой бичээгүй байна.

Засгийн газар өмнөх УИХ-аас баталсан Монгол Улсын Хөгжлийн хөтөлбөрийг өөрчилж, 1998 оны тавдугаар сард Засгийн газрын 82 дугаар тогтоолоор Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг баталсан байна. 1996 оны хөгжлийн үзэл баримтлал нь дөнгөж найман хуудастай, хэтэрхий товчхон, хөгжлийн олон асуудлыг бүрэн тусгаагүй байсан. Ялангуяа салбаруудын хөгжлийн бодлого тодорхойгүй байсан бөгөөд анх удаа хөгжлийн бодлогоо зах зээлийн нөхцөлд тодорхойлохыг оролдсон учир энэ чиглэлийн туршлага, дадлага дутсан нь тодорхой. Эндээс харахад, улс төрийн намууд тухайн үед урт хугацааны хөгжлийн бодлогоо зөвшилцдөггүй, бүх нийтээрээ хүлээн зөвшөөрсөн тохиолдолд гаргадаггүй, өөр улс төрийн намын үед баталсан хөгжлийн бодлогыг хүлээн зөвшөөрөхгүй, өөрсдийнхөөрөө өөрчилдөг, төрийн тогтвортой нэгдсэн бодлого байгаагүй зэргийг нотолж байна. Нөгөө талаас тэр үед хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль, эрх зүйн орчин хангалтгүй, улс төрийн хүчнүүд өөрсдийн дураар янз бүрийн бодлого, хөтөлбөр гаргаж, төрийн бодлогын нэгдсэн, уламжлалт чанарыг алдагдуулж байжээ³².

³¹ Монгол улсын Хөгжлийн судалгаа. Үндэсний хөгжлийн хүрээлэн. 2007.х.18

³² Үндэсний Хөгжлийн газар, Монгол улсын хөгжлийн бодлогын тогтвортой байдал,залгамж шинж чанар, уялдаанд хийсэн шинжилгээ. тайлан I. тайлан. 2018

Сонгуулийн жилүүдэд хөгжлийн үзэл баримтлал, бодлоготой хамаарах УИХ, Засгийн газрын шийдвэр, нийгэмд өрнөсөн олны анхаарлыг татсан бусад үйл явдалтай танилцъя.

1. Үнэ чөлөөлөлт. Эрчим хүч, дулаан, цахилгааны үнийг чөлөөлөв.
2. Төрийн өмчийн салбарын удирдлага, бүтцийг бүрэн шинэчлэв. Жишээ нь, “Эрдэнэт үйлдвэр”-ийн даргыг өөрчилж, үйлдвэрт онц байдал тогтоожээ.
3. Улсын орон сууцыг үнэгүй хувьчлав.
4. Улсын өмчийн үйлдвэр, албан байгууллагыг хувьчлав.
5. Банкнуудын хямрал. Төрийн банкныг хувийн компанид нийлүүлэх оролдлого хийв.
6. Татварын шинэчлэл. Гаалийн татварыг тэглэсэн явдал. Энэ нь Үндэсний үйлдвэрүүдийн хувьд хүнд цохилт болсон гэж зарим судлаачид үзжээ³³.
7. Засгийн газрын тогтворгүй байдал. Дөрвөн Засгийн газар солигдсон байдаг.
8. Тэтгэврийн нэрийн дансны тухай хууль батлагдав.
8. “Казиногийн хэрэг”-ээр УИХ-ын гишүүдийн бүрэн эрхийг түдгэлзүүлэв.
10. С.Зоригийн амь насыг хохироосон үйл явдал.
11. Төрийн албан хаагчдыг олноор халсан явдал. Ингэхдээ мөрийн хөтөлбөрт төрийн албан хаагчдыг цомхотгох гэж нэрлэсэн боловч шинээр ажил, албан тушаалд томилох явдал түгээмэл байв.
12. 2000 оны эхээр байгалийн гамшигт үзэгдэл ган зуд ихэнх аймагт нүүрлэв.

2000-2004 он:

Сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Засгийн газар 2000 оны есдүгээр сарын 1-нд мөрийн хөтөлбөрөө батлуулсан. Мөрийн хөтөлбөрийн эх үндэс нь МАХН-ын сонгуулийн хөтөлбөр гэж дурдаад, тодруулбал, намынхаа нийгмийн баримжааг анхаарч эдийн засаг, бусад асуудлыг уялдуулна гэжээ. Харин 1998 оны Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн талаар огт дурдсангүй.

Мөн Засгийн газрын үед “Ноолуур” хөтөлбөрийг хэрэгжүүлж, Монгол Улсын ноолууран бүтээгдэхүүний экспортыг өсгөж, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ гэж зорилт тавьсны үр дүнд ажлын байр нэмэгдэж, малчдын орлогод нөлөөлсөн эерэг үр дүнтэй ч малын тоо толгойд ямааны тоо ихсэж, уламжлалт мал аж ахуй, бэлчээрийн даац хэтрэх сөрөг үр дагавартай билээ. Энэ нь байгаль орчин, цөлжилтийг бий болгоход нөлөөлсөн гэж дүгнэж болно.

Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны хэмжээг жил бүр тогтвортой өсгөн 2.5 дахин нэмэгдүүлнэ. Ашигт малтмалын ордыг байгальд халгүй технологиор ашиглах эрх зүй, хяналт, урамшууллын тогтолцоог бий болгоно. Тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн байгаль орчны урт хугацааны бодлого, хөтөлбөрийг бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиглэлтэй уялдуулан үе шаттайгаар хэрэгжүүлнэ гэж заасан байна. Гэхдээ энэ зорилт нь эдийн засгийн бодлоготойгоо хэрхэн уялдах талаар зохицуулсан үйл ажиллагааны мэдээлэл байхгүй.

³³ Б.Батхшиг. Монголын эдийн засгийн хөгжлийн асуудал. 2018. х.53

1. Их өр тэглэсэн явдал. Их өрийг төлөх хэлэлцээр үргэлжилж 98 хувийг нь тэглэж, хоёр хувь буюу 250 сая ам.долларыг Монголын тал төлөх шийдвэрийг ОХУ-ын тал 2003 оны арванхоёрдугаар сард гаргасан байна.
2. 2000 оны сүүлийн байдлаар Монгол Улс дах ядуурлын түвшин 36 хувьд хүрэв.
3. Мянганы замын хэвтээ тэнхлэгийн дагуу хатуу хучилттай зам тавих
4. 2001 оноос зэсийн үнийн өсөлтөөр эдийн засаг тогтворжиж, эдийн засаг мөнгөжилт бий болсон.
5. Уул уурхайн өсөлт, ноолуурын үйлдвэрлэл өссөнөөр төсвийн орлого нэмэгдсэн ч нөөцийн сан бүрдүүлж чадаагүй байна.

2004-2008 оны УИХ-ын сонгууль:

Сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Засгийн газар 2000 оны арваннэгдүгээр сарын 5-нд мөрийн хөтөлбөрөө батлуулсан. Энэ Засгийн газрын онцлог мөн адил 1990 оны Засгийн газартай адил буюу олонх болсон МАХН Эх орон-Ардчилал эвсэлтэй зөвшилцөн эдгээр намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтууд хэрэгжүүлэхээр болсон. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 2001 онд хэр зэрэг харгалзаж, мөрийн хөтөлбөр боловсруулсан талаар харьцуулж харъя.

Үндсэн зорилгод зааснаар хувийн салбарыг өсөлтийн гол хөдөлгөгч болгон, эдийн засгийн тогтвортой өндөр өсөлтийг ханган, мэдлэг, мэдээлэлд тулгуурласан шинэ зах зээл нээхийг дэмжиж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх замаар хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах гэж тодорхойлжээ. Энэ үед байгаль, цаг уурын таатай нөхцөлтэй байсан бөгөөд эрдэс түүхий эдийн экспортын хөөсрөлтийн үетэй таарсан. Уур уурхайн салбарын нөлөө энэ үеэс манай улсын гол салбар болж тодорхойлогдсон. Энэ салбарын ДНБ-д эзлэх хэмжээ 15-28 хувьд хүрсэн. Гэтэл тус салбарт нийгмийн тэгш байдлын зарчмаар авч үзвэл ажиллах хүч бага шаарддаг ба нийт ажиллах хүчний дөрвөн хувь л хамаардаг байна³⁴.

Сонгуулийн жилүүдэд хөгжлийн үзэл баримтлал, бодлоготой хамаарах УИХ, Засгийн газрын шийдвэр, нийгэмд өрнөсөн олны анхаарлыг татсан бусад үйл явдалтай танилцъя.

1. 2005 онд зэсийн үнэ өсөж, татварын орлого эрс нэмэгдэн, улсын төсөв үлдэгдэлтэй гарсан нь нийгмийн хамгааллыг бэхжүүлэх таатай орчин бүрдэхэд нөлөөлсөн байна. Ингээд 2005 оны нэгдүгээр сард хүүхдийн мөнгө хөтөлбөр нэвтрүүлэв. 2007 оны нэгдүгээр сард бүх хүүхдэд улирал тутам 25 000 төгрөг олгодог болов.

2. Хадгаламж зээлийн хоршоодын дампуурал
3. Уул уурхайн орлого нэмэгдсэн ч төсвийн зардал ихсэв
4. Сонгууль амласан тэтгэвэр, төрийн албан хаагчдын цалингийн өсөлт инфляцад нөлөөлж байв.

³⁴ В.Данаасүрэн, Д.Чимэддагва. Тогтвортой хөгжил ба салбар хоорондын тэнцлийн шинжилгээ. 2018. Эрдэм шинжилгээний бичиг.

5. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, байгаль орчны нөхөн сэргээлт хийхгүй байгаа уул уурхайн компаниудын эсрэг иргэдийн хөдөлгөөн, жагсаал цуглааны тоо ихсэв.

2008-2012 он:

Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан Монгол Улсын Засгийн газар нь Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, 2008 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцсон МАХН болон Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөр, эдгээр намуудын Улсын Их Хурлын сонгуулийн дараа байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, бусад намуудын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн зарим зорилт, төрийн бус байгууллагын санал, олон улсын байгууллагатай хийсэн баримт бичгүүдийг үндэслэн 2008-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө тодорхойлсон байна. Өмнөх Засгийн газар нь нийгмийн томоохон зорилтуудыг хэрэгжүүлэх, төрийн албыг чадваржуулах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг хөнгөн шуурхай болгох, хувийн хэвшлийг дэмжих, эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, хөгжлийг бататгах зэрэг тулгамдсан олон асуудлыг шийдэж, цааш үргэлжлүүлэн хийж бүтээх суурийг нь тавьж өгсөн юм. Шинэ Засгийн газар өмнөх Засгийн газруудын үйл ажиллагааны залгамж чанарыг хадгалж, 2008-2012 оны үйл ажиллагааныхаа чиглэлд тусгасан болно.

Сонгуулийн жилүүдэд хөгжлийн үзэл баримтлал, бодлоготой хамаарах УИХ, Засгийн газрын шийдвэр, нийгэмд өрнөсөн олны анхаарлыг татсан бусад үйл явдалтай танилцъя.

1. Уул уурхайгаас олсон орлогоос бүрдүүлсэн Хүний хөгжлийн санд хуримтлуулсан мөнгийг иргэдэд бэлнээр тараах, “Эрдэнэс Тавантолгой” компанийн ирээдүйд олборлох нүүрсийг урьдчилж зээлж, 350 сая ам.долларыг сонгуулийн өмнө авсан байна. Зээлийн эргэн төлөлтийг зургаан жилийн турш төлж дууссан.
2. Уул уурхайгаас олсон орлогоос шалтгаалан эдийн засгийн өсөлт бүс нутагтаа 2011 онд 17 хувь болов.
3. Халамжийн бодлогыг хавтгайруулснаас ирээдүйд хуримтлах орлого, баталгаа багассан. Хүний хөгжил сангаас 2010 онд эхний удаад 70 мянган төгрөг хүн бүрд, сүүлийн таван сард сар бүр 10 мянган төгрөг, жилийн дүнгээрээ 120 мянган төгрөг, 2011 онд сар бүр 21 мянган төгрөг, жилийн дүнгээрээ 252 мянган төгрөг олгосон. Оюутны сургалтын төлбөрт 70 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилт хийлээ.
4. Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал. Даатгалын шимтгэлийн хувь хэмжээг таван пунктээр бууруулж 14 хувь болгосон.
5. ДНБ-ий үнэ өсөж эдийн засаг тэлсэн боловч Монгол Улсын гадаад өр нэмэгдсэн.
6. “Атрын III аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг 2008-2010 онд хэрэгжүүлж хэрэгцээт буудай, төмснийг 100 хувь, хүнсний ногооны 53.2 хувийг дотоодын үйлдвэрлэлээс хангах боломж бүрдүүлсэн.

7. “Шинэ Яармаг” орон сууцын цогцолбор хорооллыг барихад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор БНХАУ-ын Экспорт-импорт банканд 300 тэрбум төгрөгийн зээлийн баталгааг 12 жилийн хугацаатай хийсэн.
8. Цэцэрлэгийн хамран сургалтыг нэмэгдүүлэхэд хамгийн их нөлөөлсөн хүчин зүйлийн нэг нь 2009 оны нэгдүгээр сарын 1-нээс эхлэн төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг төрөөс бүрэн хариуцах болсон явдал билээ.
9. Байгаль орчны багц хуулиудыг шинэчлэв.
10. Оюутолгойн гэрээний асуудал.

2012-2016 он:

АН-ын “Монгол хүн” хөтөлбөрийг үндэслэн, ИЗНН-ын “Амьдрал” хөтөлбөр, МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн “Монголоо аврах таван хувьсгал” хөтөлбөрийн зарим тодорхой саналыг тусган Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг тодорхойлж байна гэжээ. Харин Үндэсний хөгжлийн цогц бодлогод нийцүүлсэн талаар мэдээлэл байхгүй ба тогтвортой хөгжлийг хангах зорилтуудыг ерөнхий агуулгаар дурдсан байна.

Сонгуулийн жилүүдэд хөгжлийн үзэл баримтлал, бодлоготой хамаарах УИХ, Засгийн газрын шийдвэр, нийгэмд өрнөсөн олны анхаарлыг татсан бусад үйл явдалтай танилцъя.

1. 580 сая ам.долларын Засгийн газрын баталгаагаар бондууд гаргаж эхэлсэн.
2. Гэр хорооллын дахин төлөвлөлт
3. Сонгуулийн автоматжуулсан төхөөрөмж
4. “Дубайн гэрээ”
5. Оюутолгойн далд уурхайн гэрээний асуудал

2016-2020 он:

Улсын Их Хурлын ээлжит долоо дахь удаагийн сонгуулийн дараа шинээр байгуулагдсан Монгол Улсын Засгийн газар нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, 2016 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцсон Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөр, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд сонгогчдын санал, олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд үндэслэн 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө тодорхойлжээ.

Сонгуулийн жилүүдэд хөгжлийн үзэл баримтлал, бодлоготой хамаарах УИХ, Засгийн газрын шийдвэр, нийгэмд өрнөсөн олны анхаарлыг татсан бусад үйл явдалтай танилцъя.

1. Нийгмийн даатгал, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх
2. Тэтгэврийн зээлийг нэг удаа тэглэх
3. Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх шударга ёс тогтоох тэмцэл
4. “Ковид-19” буюу цар тахлын нөхцөл байдал үүссэн
5. Хүүхдийн 100 000 төгрөг


4.4 Сонгогч Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, бодлогыг ухамсарлан саналаа өгдөг, эсэх

Судалгаанд нийт 130 хүн оролцсон болно.

1990 оны АИХ-ын сонгууль:

Нийт санал асуулгад оролцсон 130 хүнээс 33 нь 1990 оны сонгуульд оролцсон, 1972 оны долоодугаар сараас өмнө төрсөн иргэд байв. Эдгээр иргэний санал асуулгыг эхлүүлэхдээ шүүлтүүр асуултын тусламжтайгаар түүвэр хийлээ.

Зураг 2. Асуулт 1: Та намуудын сонгуулийн хөтөлбөрийг судалж саналаа өгсөн үү?



Тайлбар: Нийт 33 хүнээс маш сайн судалсан, сайн судалсан гэж тус бүр нэг хүн, дунд зэрэг гэж хоёр, бараг судлаагүй болон огт судлаагүй гэж тус бүр гурав, сайн санахгүй байна гэж 23 хүн хариулжээ.


Зураг 3. Асуулт 2: Тухайн үеийн БНМАУ-ын хөгжлийн үзэл баримтлалыг санаж байна уу гэсэн асуултыг авсан.



Тайлбар: Судалгаанд оролцсон нийт 33 хүнээс 18 нь хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм гэж 1992 оны Үндсэн хуулийн эрхэм зорилгыг дугуйлжээ. Харин энэ үеийн хөгжлийн үзэл баримтлалыг БНМАУ-ын Үндсэн хуульд ардчилсан социализм байгуулах гэж тодорхойлсон. Үүнийг мэддэг хүн нэг байсан бөгөөд харин нөгөө хоёр сонголт буюу хөрөнгөтний, капиталист гэсэн хариултыг тус бүр нэг, нэг хүн дугуйлсан байна.

Тухайн үед 1200 иргэнээс авсан судалгаанд “Зах зээлийн нөхцөлд шилжиж, бид сайн ажиллаж чадвал сайхан амьдарна” гэсэн хариултад гурван хүн тутмын нэг нь тийм гэж хариулж байжээ³⁵.

Зураг 4. Асуулт 3: Таны дэмжиж санал өгсөн намын мөрийн хөтөлбөрт заасан зорилт өнөө цаг үе хүртэл бодитой хэрэгжиж чадсан уу?



Тайлбар: Нэгдүгээр асуултад бараг судлаагүй, огт судлаагүй, сайн санахгүй байна гэсэн хариулт өгсөн нийт 26 хүнээс энэ асуултыг аваагүй болно.

Иргэдээс тухайн үед буюу 1990 онд сонгууль өгөхдөө “мөрөөдөж” байсан үр дүн 30 жилийн дараа биелсэн, эсэхийг тандах зорилгоор *өнөө цаг үе* гэж түлхүүр үг ашигласан. Нийт долоон хүн энэ санал асуулгад оролцов. 90-ээс дээш, 70-90 хувь гэсэн хариултыг нэг ч хүн сонгосонгүй. 50-70 хувь гэсэн хариултыг дөрөв, 30-50 болон 10-30 хувь гэсэн хариултыг тус бүр нэг хүн өгсөн бол огт хэрэгжээгүй гэж нэг ч хүн хариулаагүй, сайн хэлж мэдэхгүй гэсэн сонголтыг нэг хүн сонгожээ.

Энэ асуултыг дагаж нээлттэй асуулт тавьсан. *Асуулт: Та ямар зорилтыг нь дэмжиж байснаа жишээгээр хэлнэ үү?*

Хариулт: Ардчилсан нийгэм байгуулах, хүний эрхийг дээдлэх, зах зээлийн эдийн засагт шилжих, олон намын тогтолцоо, дарга нарын өмчийг хураах, хувийн өмчтэй болгох, малыг хувьд шилжүүлэх, гадаадад гарах, улсын үйлдвэрийг хувьчлах, үг хэлэх зэргээр бичжээ. Хамгийн их давтагдсан үг бол ардчилсан нийгэм байгуулах, зах зээлийн эдийн засаг, хүний эрхийг дээдлэхтэй холбоотой байв. Сайн хэлж чадахгүй байна гэсэн нэг хүнд энэ асуултыг тавиагүй болно.

Мөн 1991 оны судалгаанд хамрагдсан иргэдийн 51 хувь нь хөгжлийн ямар замд орж байгаагаа үнэлж чадахгүй, эсвэл буруу замд орлоо гэж эмзэглэж байсан байна³⁶.


³⁵ Ц.Уртнасан. Монголын нийгмийн бүтцийн судалгаа шинжилгээ бүтээлийн эмхтгэл. 2017.х.224.

³⁶ Ц.Уртнасан. Монголын нийгмийн бүтцийн судалгаа шинжилгээ бүтээлийн эмхтгэл. 2017.х.213

1992-1996 оны сонгууль:

1992 оны сонгуульд оролцсон 47 иргэн байлаа. Энэ санал асуулгад 1974 оны зургадгаар сараас өмнө төрсөн хүмүүс нэмэгдсэн болно.

Зураг 5. Асуулт 1: Та намуудын сонгуулийн хөтөлбөрийг судалж саналаа өгсөн үү?




Тайлбар: Нийт 47 хүнээс маш сайн судалсан нэг, сайн судалсан гэж тав, дунд зэрэг гэж 12, бараг судлаагүй гэж нэг, огт судлаагүй гэж гурав, сайн санахгүй байна гэж 25 хүн хариулжээ.

Зураг 6. Асуулт 2: Тухайн үеийн Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг санаж байна уу гэсэн асуултыг авсан.



Тайлбар: Судалгаанд оролцсон нийт 47 хүнээс 17 нь хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм гэж 1992 оны Үндсэн хуулийн эрхэм зорилгыг дугуйлжээ. Капиталист нийгэм байгуулах болон тогтвортой хөгжлийг хангах гэж нэг ч хүн хариулаагүй. Харин сайн санахгүй байна гэж 20 хүн хариуллаа.

Зураг 7. Асуулт 3: Таны дэмжиж санал өгсөн намын мөрийн хөтөлбөрт заасан зорилт өнөө цаг үе хүртэл бодитой хэрэгжиж чадсан уу?



Тайлбар: Нэгдүгээр асуултад бараг судлаагүй, огт судлаагүй, сайн санахгүй байна гэсэн хариулт өгсөн нийт 29 хүнээс энэ асуултыг аваагүй болно.

Нийт 18 хүн энэ санал асуулгад оролцов. 90-ээс дээш, 70-90 хувь гэсэн хариултыг нэг ч хүн сонгосонгүй, 50-70 хувь гэж долоо, 30-50 хувь гэж гурав, 10-30 хувь гэж нэг хүн хариулсан бол огт хэрэгжээгүй гэсэн сонголтыг нэг ч хүн сонгоогүй, сайн хэлж мэдэхгүй гэж долоон хүн тус тус хариулжээ.

Энэ асуултыг дагаж нээлттэй асуулт тавьсан. *Асуулт: Та ямар зорилтыг нь дэмжиж байснаа жишээгээр хэлнэ үү?*

Хариулт: Зах зээлийн эдийн засаг, өмч хувьчлалыг шударга байлгах, барааны хомстлоос гарах, үйлдвэрүүдийг сэргээх, цэнхэр ягаан тасалбарыг бодитой орлого болгоогүй, ажилгүйдлийг багасгах, эмх замбараагүй байдлыг таслан зогсоох зэргийг дурдаж байв.

Хамгийн их давтагдсан үг бол ардчилсан нийгэм байгуулах, өмч хувьчлалыг шударга байлгах гэсэн түлхүүр үг байлаа.


Тухайн үеийн социологийн хүрээлэнгээс сонгуулийн дараа буюу 1993 онд явуулсан судалгаанаас оролцогсдын 70 гаруй хувь нь улс орноо хөгжлийн ямар замд орсныг тодорхойлж чадахгүй гэж хариулсан байна³⁷. Энэ нь намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр сонгуульд ялсан намын УИХ, Засгийн газрын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгүүдэд хангалттай тусгагдаж чадаагүйтэй холбоотой юм.

1996-2000 он:

1996 оны сонгуульд оролцсон 50 иргэн байлаа. Тэд 1978 оны зургадгаар сараас өмнө төрсөн.

³⁷ Ц.Уртнасан. Монголын нийгмийн бүтцийн судалгаа шинжилгээ бүтээлийн эмхэтгэл. 2017.х.192.

Зураг 8. Асуулт 1: Та намуудын сонгуулийн хөтөлбөрийг судалж саналаа өгсөн үү?




Тайлбар: Нийт 50 хүнээс маш сайн судалсан гэж нэг, сайн судалсан долоо, дунд зэрэг судалсан гэж 23, бараг судлаагүй гэж тав, огт судлаагүй гэж зургаа, сайн санахгүй байна гэж найман хүн хариулжээ.

Зураг 9. Асуулт 2: Тухайн үеийн Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын бодлогын баримт бичгийг санаж байна уу?



Тайлбар: Судалгаанд оролцсон нийт 50 хүнээс НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр гэж хоёр, хүнлэг энэрэнгүй ардчилсан нийгэм байгуулах гэж 32, 1996 онд батлагдсан Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлал гэж нэг, сайн санахгүй байна гэж 16 хүн тус тус хариулжээ.

Зураг 10. Асуулт 3: Таны санал өгсөн намын мөрийн хөтөлбөрт заасан зорилт өнөө цаг үе хүртэл бодитой хэрэгжиж чадсан уу?



Тайлбар: Нэгдүгээр асуултад бараг судлаагүй, огт судлаагүй, сайн санахгүй байна гэсэн хариулт өгсөн нийт 19 хүнээс энэ асуултыг аваагүй болно.

Нийт 31 хүн энэ санал асуулгад оролцов. 90-ээс дээш хувь гэж нэг ч хүн хариулаагүй бол 70-90 хувь гэж нэг, 50-70 хувь гэж дөрөв, 30-50 хувь гэж 15, 10-30 хувь гэж хоёр, огт хэрэгжээгүй гэж гурав, сайн хэлж мэдэхгүй гэж зургаан хүн тус тус хариулжээ.


Энэ асуултыг дагаж нээлттэй асуулт тавьсан. *Асуулт: Та ямар зорилтыг нь дэмжиж байснаа жишээгээр хэлнэ үү?*

Хариулт: төр засгийн үйл ажиллагаа ил тод байх, хувийн хэвшлийг дэмжих, цалин хөлс нэмэх, ардчилал, эрх, эрх чөлөө, төрийн албаны халаа сэлгээ, Засгийн газрын тогтвортой байдал зэргийг хамгийн ихээр дурдсан байна.

2000-2004 он:

2000 оны сонгуульд оролцсон 53 иргэн байлаа. Тэд 1982 оны зургадгаар сараас өмнө төрсөн.

Зураг 11. Асуулт 1: Та намуудын сонгуулийн хөтөлбөрийг судалж саналаа өгсөн үү?




Тайлбар: Нийт 53 хүнээс маш сайн судалсан, сайн судалсан гэж тус бүр дөрөв, дунд зэрэг гэж 20, бараг судлаагүй гэж долоо, огт судлаагүй гэж 10, сайн санахгүй байна гэж таван хүн хариулжээ.

Зураг 12. Асуулт 2: Тухайн үеийн Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг санаж байна уу гэсэн асуултыг авсан.



Тайлбар: Судалгаанд оролцсон нийт 53 хүнээс эхний хариултыг нэг хүн, 2, 3 дахь хариултыг тус бүр 26 хүн сонгожээ.

Зураг 13. Асуулт 3: Таны дэмжиж санал өгсөн намын мөрийн хөтөлбөрт заасан зорилт өнөө цаг үе хүртэл бодитой хэрэгжиж чадсан уу?



Тайлбар: Нэгдүгээр асуултад бараг судлаагүй, огт судлаагүй, сайн санахгүй байна гэсэн хариулт өгсөн нийт 22 хүнээс энэ асуултыг аваагүй болно.

Нийт 31 хүн энэ санал асуулгад оролцов. 90-ээс дээш хувь гэж нэг ч хүн хариулаагүй бол 70-90 хувь гэж нэг, 50-70 хувь гэж 14 хүн, 30-50 хувь гэж нэг, 10-30 хувь гэж гурав, сайн хэлж мэдэхгүй гэж 11 хүн тус тус хариулжээ.


Энэ асуултыг дагаж нээлттэй асуулт тавьсан. *Асуулт: Та ямар зорилтыг нь дэмжиж байснаа жишээгээр хэлнэ үү?*

Хариулт: төрийн тогтвортой байдал, ядуурлыг бууруулах, сахилга дэг журам, бизнесийг дэмжих, үнийн өсөлтийг зогсоох, орлого нэмэгдүүлэх зэрэг үг хамгийн олон давтагдсан.

2004-2008 он:


2004 оны сонгуульд оролцсон 52 иргэн байлаа. Иймд энэ санал асуулгад 1986 оны зургадгаар сараас өмнө төрсөн хүмүүс нэмэгдсэн болно.

Зураг 14. Асуулт 1: Та намуудын сонгуулийн хөтөлбөрийг судалж саналаа өгсөн үү?




Тайлбар: Нийт 52 хүнээс маш сайн судалсан гэж нэг, сайн судалсан гэж ес, дунд зэрэг гэж 32, бараг судлаагүй гэж нэг, огт судлаагүй гэж гурав, сайн санахгүй байна гэж зургаан хүн хариулжээ.

Зураг 15. Асуулт 2: Тухайн үеийн Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг санаж байна уу гэсэн асуултыг тавьсан.



Тайлбар: Судалгаанд оролцсон нийт 52 хүнээс эхний хариултыг долоо, хоёр дахийг 30, гурав дахийг 15 хүн сонгожээ.

Зураг 16. Асуулт 3: Таны дэмжиж санал өгсөн намын мөрийн хөтөлбөрт заасан зорилт өнөө цаг үе хүртэл бодитой хэрэгжиж чадсан уу?



Тайлбар: Нэгдүгээр асуултад бараг судлаагүй, огт судлаагүй, сайн санахгүй байна гэсэн хариулт өгсөн нийт 10 хүнээс энэ асуултыг аваагүй болно.


Нийт 42 хүн энэ санал асуулгад оролцов. 90-ээс дээш хувь гэж нэг ч хүн хариулаагүй бол 70-90 хувь гэж дөрөв, 50-70 хувь гэж 17, 30-50 хувь гэж 11, 10-30 хувь гэж нэг, огт хэрэгжээгүй гэж хоёр, сайн хэлж мэдэхгүй гэж 17 хүн тус тус хариулжээ. Энэ асуултыг дагаж нээлттэй асуулт тавьсан. *Асуулт: Та ямар зорилтыг нь дэмжиж байснаа жишээгээр хэлнэ үү?*

Хариулт: Залуу гэр бүлд 500 000, хүүхдийн 10 000, уул уурхай гэдэг үгс хамгийн их давтагдсан.

2008-2012 он:

2008 оны сонгуульд оролцсон 49 иргэн байлаа. Иймд энэ санал асуулгад 1990 оны зургадгаар сараас өмнө төрсөн хүмүүс оролцсон.

Зураг 17. Асуулт 1: Та намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг судалж саналаа өгсөн үү?




Тайлбар: Нийт 49 хүнээс маш сайн судалсан гэж гурав, сайн судалсан гэж 11, дунд зэрэг гэж 23, бараг судлаагүй гэж гурав, огт судлаагүй гэж нэг, сайн санахгүй байна гэж найман хүн хариулжээ.

Зураг 18. Асуулт 2: Тухайн үеийн Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг санаж байна уу гэсэн асуултыг авсан.



Тайлбар: Судалгаанд оролцсон нийт 49 хүнээс эхний хариултыг 12, 2 дахийг 10, 3 дахийг 17 хүн сонгожээ.

Зураг 19. Асуулт 3: Таны дэмжиж санал өгсөн намын мөрийн хөтөлбөрт заасан зорилт өнөө цаг үе хүртэл бодитой хэрэгжиж чадсан уу?



Тайлбар: Нэгдүгээр асуултад бараг судлаагүй, огт судлаагүй, сайн санахгүй байна гэсэн хариулт өгсөн нийт 12 хүнээс энэ асуултыг аваагүй болно.

Нийт 37 хүн энэ санал асуулгад оролцов. 90-ээс дээш хувьтай гэж нэг ч хүн хариулаагүй бол 70-90 хувь гэж дөрөв, 50-70 хувь гэж 11, 30-50 хувь гэж зургаа, 10-30 хувь гэж зургаа, огт хэрэгжээгүй гэж хоёр, сайн хэлж мэдэхгүй гэж долоон хүн тус тус хариулжээ.


Энэ асуултыг дагаж нээлттэй асуулт тавьсан. Асуулт: Та ямар зорилтыг нь дэмжиж байснаа жишээгээр хэлнэ үү?

Хариулт: Байгалийн баялгийн шударга хуваарилалт, авлигатай тэмцэх, шударга ёс тогтоох, уул уурхайг хязгаарлах, байгаль орчныг хамгаалах, 1 500 000, 1 000 000 төгрөг гэсэн үгс хамгийн их давтагдсан.

2012-2016 он:

2012 оны сонгуульд оролцсон 56 иргэн байлаа. Иймд энэ санал асуулгад 1994 оны зургадугаар сараас өмнө төрсөн хүмүүс санал асуулгад оролцсон.

Зураг 20. Асуулт 1: Та намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг судалж саналаа өгсөн үү?



Тайлбар: Нийт 56 хүнээс маш сайн судалсан гэж долоо, сайн судалсан гэж 24, дунд зэрэг гэж 19, бараг судлаагүй болон огт судлаагүй гэж нэг, сайн санахгүй байна гэж гурван хүн хариулжээ.

Зураг 21. Асуулт 2: Тухайн үеийн Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг санаж байна уу гэсэн асуултыг авсан.



Тайлбар: Судалгаанд оролцсон нийт 56 хүнээс эхний хариултыг найм, 2 дахийг 40, 3 дахийг найман хүн сонгожээ.


Асуулт 3. Таны санал өгсөн намын мөрийн хөтөлбөрт заасан зорилт өнөө цаг үе хүртэл бодитой хэрэгжиж чадсан уу?

Энэ асуултыг урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал, шалгуурын дагуу хугацаа нь болоогүй гэж үзэн авсангүй.

2016-2020:


2016 оны сонгуульд оролцсон 70 иргэн байлаа. Иймд 1998 оны зургадугаар сараас өмнө төрсөн хүмүүс санал асуулгад оролцсон.

Зураг 22. Асуулт 1: Та намуудын сонгуулийн хөтөлбөрийг судалж саналаа өгсөн үү?



Тайлбар: Нийт 70 хүнээс маш сайн судалсан гэж гурав, сайн судалсан гэж 11, дунд зэрэг гэж 23, бараг судлаагүй гэж гурав, огт судлаагүй гэж нэг, сайн санахгүй байна гэж найман хүн хариулжээ.

Зураг 23. Асуулт 2: Тухайн үеийн Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг санаж байна уу гэсэн асуултыг авсан.



Тайлбар: Судалгаанд оролцсон нийт 70 хүнээс эхний хариултыг 12, 2 дахийг 10, 3 дахийг 17 хүн сонгожээ.

Асуулт 3. Таны санал өгсөн намын мөрийн хөтөлбөрт заасан зорилт өнөө цаг үе хүртэл бодитой хэрэгжиж чадсан уу?

Энэ асуултыг урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал, шалгуурын дагуу хугацаа нь болоогүй гэж үзэн санал авсангүй.

ТАВДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ

1960-аад оноос НҮБ болон түүний харьяа байгууллагууд нь хөгжлийг эдийн засгийн өсөлттэй адилтгадаг үзэл баримтлал, түүнтэй төсөөтэй онолуудыг баримталж байв³⁸. Харин техникийн дэвшил эдийн засгийн өсөлт зэрэг нь тухайн цаг үетэйгээ л холбогддог, гарах үр дагавар хэтдээ сайнаар бас сөргөөр ч нөлөөлдөг.

Иймд хүн төрөлхтөн хөгжлийн зөвхөн эдийн засгийн хэрэглээний онолд тулгуурлан цаашид явах аваас манай дэлхийд байгаль орчны сүйрэл, эдийн засгийн хямрал, нийгмийн шударга бус байдал улам нэмэгдэх юм байна гэдгийг танин мэдсэний үр дүнд, ирээдүйд чиглэсэн, хувьсал өөрчлөлтөд нээлттэй тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын загварыг боловсруулсан. Энэхүү холбоо, хамаарлын харьцааг зохистой хэмжээнд уялдуулан зохицуулж, зорилгод түвшинд нь хүргэхэд улс төрийн хүчин зүйл буюу улс төрийн тогтолцоо, түүний бүрдэл хэсгүүдийн зөв төлөвшил, хууль тогтоомжийн оновчтой зохицуулалт шийдвэрлэх үүрэгтэй.

Тогтвортой хөгжилд нөлөөлөх улс төр, эрх зүйн хүчин зүйлсийг тогтвортой хөгжлийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд, суурь зарчмуудаас ургуулан сонгуулийн тогтолцооны хувилбарыг тодорхойлох боломжтой гэж үзлээ. Ингэхийн тулд дараах судалгааны асуултад хариулж, судалгааны таамаглалаа шалгах шаардлага гарч ирнэ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

³⁸ Мөн тэнд

Судалгааны асуулт 1. 1992-2016 оны сонгуульд оролцсон намуудын мөрийн хөтөлбөрт Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлал, бодлогын баримт бичигт заасан зорилтууд тусгагдсан, эсэх

№	Сонгууль тогтолцоо	Намын сонгуулийн хөтөлбөр ба Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал	МАХН	Ардчилсан хүчний эвсэл	Гуравдагч хүчин
		1990	Үндсэн хуульд хүчинтэй байгаа эрхэм зорилгыг дурдаагүй		
	Томгосон мажоритар	1992	Бие даасан бодлогын баримт бичиг гараагүй, гэхдээ Үндсэн хуульд заасан эрхэм зорилгыг тунхаг шинжтэй дурдсан		
	Жижиг Мажоритар	1996-Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлал	Үгүй	Үгүй	Үгүй
	Жижиг Мажоритар	2000-Монгол улсын Тогтвортой хөгжлийн Үндэсний хөтөлбөр	Үгүй	Дунд зэрэг	Дунд зэрэг
	Жижиг Мажоритар	2004-Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал	Дунд зэрэг	Үгүй	Дунд зэрэг
	Томгосон мажоритар	2008- Үндэсний хөгжлийн цогц бодлого	Дунд зэрэг	Үгүй	Дунд зэрэг
	Хосолсон	2012-Үндэсний хөгжлийн цогц бодлого	Дунд зэрэг	Үгүй	Дунд зэрэг
	Жижиг Мажоритар	2016- Монгол Улсын Тогтвортой хөгжил-2030	Үгүй	Бүрэн	Дунд зэрэг


Судалгааны асуулт 2. 1992-2016 оны төр засгийн шийдвэрт Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлал, бодлогын баримт бичигт заасан зорилтууд тусгагдсан, эсэх

№	Сонгууль тогтолцоо	Засгийн газрын хөтөлбөр ба Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал	МАХН	Ардчилсан хүчний эвсэл	Гуравдагч хүчин
		1990	Нийгмийн өөрчлөлтийн улмаас БНМАУ-ын Үндсэн хуулийн зорилгыг дагах боломжгүй тул харгалзаагүй гэж үзэж болно.	Засгийн эрх баригч биш	
	Томсгосон мажоритар	1992	Сонгуулийн жилүүдэд гурван жил таван сарын хугацаанд бие даасан бодлогын баримт бичиг гараагүй	Засгийн эрх баригч биш	
	Жижиг Мажоритар	1996- Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлал	Засгийн эрх баригч биш	Сонгуулийн жилүүдийн эхний хоёр жилд харгалзаагүй, сүүлийн хоёр жилд шинээр өөр бодлогын баримт бичиг баталсан ч тунхгийн шинжтэй хэрэгжүүлсэн	Засгийн эрх баригч биш
	Жижиг Мажоритар	2000-Монгол Улсын Тогтвортой хөгжлийн Үндэсний хөтөлбөр	Сонгуулийн жилүүдийн эхний нэг жилд нь харгалзаагүй, хоёр дахь жилээс шинээр бодлогын баримт бичиг баталсан	Засгийн эрх баригч биш	
	Жижиг Мажоритар	2004-Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал	Хамтарсан Засгийн газрын хөтөлбөрт зарим зорилтууд багтсан		Засгийн эрх баригч биш

	Томсгосон мажоритар	2008- Үндэсний хөгжлийн цогц бодлого	Хамтарсан Засгийн газрын хөтөлбөрт зарим зорилтууд багтсан		Засгийн эрх баригч биш
	Хосолсон	2012-Үндэсний хөгжлийн цогц бодлого	Засгийн эрх баригч биш	Сонгуулийн жилүүдийн эхний гурван жилд харгалзаагүй, сүүлийн жилийн эцсээр гэхэд шинээр бодлогын баримт бичиг баталсан.	Засгийн эрх баригч биш
	Жижиг Мажоритар	2016- Монгол Улсын Тогтвортой хөгжил-2030	Сонгуулийн жилүүдийн эхний гурван жилд харгалзаагүй, сүүлийн жилийн эцэс гэхэд шинээр бодлогын баримт бичиг баталсан.	Засгийн эрх баригч биш	

Судалгааны асуулт 3. Сонгогчийн саналаа өгөхдөө Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалыг анхаардаг, эсэх

Судалгаанд оролцсон нийт 130 хүний есөн сонгуульд оролцсон дүнд шинжилгээ хийхэд



Маш сайн мэддэг гэж 12, сайн мэддэг гэж 15, дунд зэрэг гэж 33, бараг мэддэггүй гэж 12, огт мэдэхгүй гэж 11, сайн санахгүй гэж 47 хүн тус тус хариулжээ.

1990 оноос хойш сонгууль тасралтгүй өгсөн 11 хүний хариултын өсөлтийг харахад дундаж нас 40-өөс дээш хүрэхэд урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалыг харгалзах, ирээдүйд хүрэх үр дүнг сонирхдог дүр зураг харагдаж байна.

1990 оноос хойш төрсөн нийт 32 хүний хариултад дүн шинжилгээ хийхэд ур хугацааны хөгжлийн үзэл баримтлалыг харгалзан саналаа өгдөг нь дөнгөж 10 хувьтай байна.

Судалгааны таамаглал:

1. Сонгуулийн мөрийн хөтөлбөр, төр засгийн шийдвэрүүд нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай харилцан уялдаа бүхий байдаггүйгээс өнөөгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны хямрал гарч байна.

Хариулт: 1990 оноос хойших урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал, бодлогын зохицуулалт 1.5-7 жилийн хугацааны үйлчлэлтэй тогтворгүй байгаа нь өнөөгийн хямралыг бий болгож байна.

2. Сонгогчийн тогтвортой хөгжлийн талаарх мэдлэг, мэдээлэл хангалтгүйгээс тэдний сонголтод нөлөөлж байна.

Хариулт: Санал асуулгад оролцсон иргэдээс урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал буюу тогтвортой хөгжлийн талаар мэдлэг мэдээлэл хангалттай байхгүй байна.

3. Сонгогчийн тогтвортой хөгжлийн талаарх итгэл үнэмшил хангалтгүй байдалд улс төрийн намууд зөвхөн сонгуульд ялах ойрын зайн бодлого дэвшүүлдэг.

Хариулт: Намуудын сонгуулийн хөтөлбөр, ялсан намын Засгийн газрын мөрийн хөтөлбөрүүд урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн, харгалзах зарчим тогтоогүй 30-аад жил явж иржээ.

4. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалыг тогтвортой байлгахад сонгуулийн холимог хувилбар сонгох нь оновчтой.

Хариулт: Сонгогч урт хугацааны хөгжлийн талаар мэдлэг, мэдээлэл сул байгаа тул тэд мажоритар тогтолцооны сул тал болох нэр дэвшигчийн сурталчилгаанд автах хүчин зүйл өндөр байна. Энэ тохиолдолд хосолсон хувилбараар сонгуульд оролцох намын хөтөлбөр нь сонгогчийн сул талыг нөхөх боломжтой гэж үзэх боловч өмнөх сонгуулийн үйл явцад дүгнэлт хийхэд улс төрийн намуудын хөтөлбөр, төр засгийн шийдвэрт урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал зарчим болж чадахгүй байна. Иймд мөн улс төрийн намын төлөвшил чухал хүчин зүйлс болно.

Эцсийн дүгнэлт: Монгол Улсын улс төрийн нам, сонгогчийн итгэл үнэмшилд урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал, бодлогын талаар мэдлэг мэдээлэл хангалттай байж чадахгүй тохиолдолд өнөөгийн бий болж буй хямралуудад чанарын өөрчлөлт гарахгүй гэж дүгнэлээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Ц.Мөнхцэцэг. Сонгуулийн кампанийн коммуникаци. 2018.

Г.Жаргал. Судалгааны арга зүйд өөрөө сурах бичиг. 2018 он.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх субъектив хүчин зүйлсийн шинжилгээ. ШУА, Философийн хүрээлэн. 2019.

Б.Чимэд. Үндсэн хуулийн үзэл баримтлал. 2004, 2016, 2017 он.

Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус). 2017

БНМАУ хөрөнгөтний биш хөгжлийн төлөө тэмцэлд (1925-1940). Баримт бичгийн эмхэтгэл. Улсын хэвлэл. УБ, 1956.

Т.Лхагваа нар. Ардчиллын замнал: алдаа-оноо, сургамж-сорилт. (түүхэн товчоо).2019
Яагаад ардчилал гэж”.....2012

Д.Бямбасүрэн. Үүрийн жавар. 1996

Г.Хэрлэн. Засгийн газар. 1990-2016 . эмхэтгэл. 2016

Ч.Ган-Өлзий. Тогтвортой хөгжил: оюуны ертөнцийн философи. 2018

Ц.Уртнасан. Монголын нийгмийн бүтцийн судалгаа шинжилгээ бүтээлийн эмхэтгэл. 2017

Монгол төрийн эдийн засгийн бодлого: сорилт, сургамж, асуудал.1911-2018

Монгол Улсын хөгжлийн судалгаа. Үндэсний хөгжлийн хүрээлэн. 2006

Ж.Амарсанаа, О.Батсайхан. Монгол улсын Үндсэн хууль. 2004

Б.Батхишиг. Монголын эдийн засгийн хөгжлийн асуудал. 2018.



Гадаад хэл дээр:

Jair Soares Jr, Rogério H. Quintella. Devolpoment: Analysis of concept, measurement and indicators

Wade. R. Governig the market. Economic theory and the role of government in East Asia industration